Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1. | Соёл урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл” арга хэмжээг нэмэгдүүлнэ | - | - | - | - | Соёлын яамнаас цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй CREATIVEHUB, GLAM системүүдийг ашиглахаас гадна статистикийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд сумдын статистик мэдээ хариуцсан ажилтнуудад системийн сан бүрдүүлэх дадлага ажлыг танхимаар зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулан 2021-2023 оны жилийн эцсийн СУ , СУХС мэдээг байршуулж мэдээллийн бааз үүсгэлээ. Шинээр хэрэгжиж буй номын сангийн КОХА системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй ERP системийг салбарын 16 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлэн АЗДТГ-аас арга зүйн сургалтыг 2 удаа авч сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглан албан ажилдаа хэрэглэж хэвшсэн. СУГ нь эхний хагас жилд ERP системээр 130 албан бичиг хүлээн авч, 84 албан бичиг бусад байгууллагад илгээж ажиллалаа. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shilen.gov.mn системд тайлант оны 06 сараас эхэлж бүртгэл үүсгэн нийтэд ил тод мэдээллэх мэдээллүүдийг оруулж хөгжүүлэлтийг хийхээр боллоо. Мөн салбарын ХШҮ-ний moc.igovernment.mn цахим сан, Гүйцэтгэлийн удирдлагын moc.igovernment.mn систем болон Дорноговь аймгийн ХШҮ-ний dornogovi.unelgee.gov.mn цахим сангуудыг Соёл урлагийн газар болон 3 нэгж байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж, төлөвлөлт болон гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж хэвшсэн. Төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор Салбарын нэгдсэн портал сайт болон салбарын 18 байгууллагууд бүгд цахим хуудас ашиглаж мэдээ мэдээллийг хүргэж хэвшсэн ба дагагчдын тоо 59,344 нь өмнөх онтой харьцуулахад 38,3%-аар өссөн. Соёл урлагийн газар нь сэтгэл ханамжийн судалгааг QR код үүсгэн цахим хуудсаар авдаг бол "Саран Хөхөө" театр нь үзэгчдийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сандал бүрийн ард байршуулж авдаг онцлогтой. Бүх нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр сумдын соёлын төвүүд "Т-энтертайнмент"-тай гэрээ байгуулж 7 хоног тутам шинэ киногоор үйлчилсэн нь томоохон төв суурин газрын соёлын үйлчилгээг орон нутгаас авах боломжийг бүрдүүлсэн. | |
| 1.1.1 | Номын санд "Үүлэн сервер" электрон каталогт номын фондыг нэмэгдүүлж, интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэх | ОНТ | Шинээр нэмэгдсэн номын тоо Электрон каталогт бүртгүүлсэн номын тоо | Шинээр нэмэгдсэн ном-590 Электрон каталогт бүртгэлтэй номын тоо-40000 | Эхний хагас жилд: Шинээр нэмэгдсэн ном-200 Электрон каталогт бүртгэлтэй номын тоо-20000 Жилийн эцэст: Шинээр нэмэгдсэн ном-390 Электрон каталогт бүртгэлтэй номын тоо-20000 | Аймгийн Засаг даргын захирамжааар 2,740,000 төгрөгийг шийдвэрлэн " Үүлэн сервер" электрон каталогийг 4 жил дараалан нэвтрүүлж аймгийн төв номын сан үйл ажиллагаандаа ашиглаж байна . Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд жил бүр энэхүү программын үйлчилгээний төлбөрийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж бусад аймгуудын номын сангаас давуу байдал бий болгож уншигчдийн талархлыг хүлээсээр ирлээ. Оны эхний хагас жилийн байдлаар электрон каталогт 110 ширхэг номыг шинээр бүртгэн уншлага үйлчилгээнд гаргасан байна. Энэхүү электрон каталогоос гадна Монгол улсын Соёлын яамнаас улсын хэмжээнд нэвтрүүлж буй "Коха" программын эхний сургалтад аймгийн төв номын сангийн дарга Б. Баттогтох хамрагдлаа.Соёл урлагийн байгууллагуудын орчин ба үйлчилгээний стандартын судалгааг Соёлын яаманд хүргүүллээ.Интернэтэд суурилсан үйлчилгээг бий болгох хүрээнд аймгийн төв номын сангийн албан хаагчид болон сумдын номын санчид хамтран Өргөн, Улаанбадрах сумын соёлын төвийн номын сангийн стандартыг хангуулах, ашиглаж буй программд уншигчид, номын санчдыг идэвхтэй хэрэглээг бий болгох, уншигчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Электрон каталогт шинээр 110 номыг бүртгэн уншлага үйлчилгээнд гаргаж нийт бүртгэлтэй номын тоо 40110 боллоо. | 70% |
| 1.1.1 | Музейн үйлчилгээг цахимжуулж Virtual reality VR төхөөрөмжийг нэвтрүүлэх | ОНТ 34.5 | төхөөрөмжний тоо | - | Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 3 | Аймгийн Музей, сургалт судалгааны төвөөс МУИС-ийн дэргэдэх "Digital Solution" компаны Захирал А.Энхбаяраар VR төхөөрөмжөөр харуулах Монгол орны уул нурууд, гол мөрөн, түүхийг харуулсан урьдчилан бэлтгэсэн 23 контент бүхий материалыг авах болсноос гадна дээрх 23-н бүтээл дээр нэмэлтээр Дорноговь аймгийн болон Хамарын хийд, музейн үзмэр,танхимууд, түүх соёлын дурсгалт газруудаар нэмэлт 3 контент бүтээх бэлтгэлийг хангалаа .Музейн үйлчилгээнд VR төхөөрөмжийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд контент бэлтгэн 5 төхөөрөмжийн шаардагдах 34,5 сая төгрөгийн төсвийн зардлыг шийдүүлэхээр аймгийн Засаг даргад 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 100 тоот албан бичгээр хүргүүллээ.Тэдгээр 23 контенттэй VR нь 1 ширхэгийн үнэ 2,900,000 төгрөг бөгөөд нэмэлт 3 контент нь 20,000,000 төгрөгийн төсөв санхүүжилтийн тооцоо судалгааг гаргасан бөгөөд зардлыг орон нутгийн төсвөөс шийдүүлэхээр ажиллалаа. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: VR төхөөрөмжид шаардагдах 34,5 сая төгрөгийн зардлын төсвийг гаргаж аймгийн Засаг даргад 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 100 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | |
| 1.1.1.4 | Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн CREATIVEHUB -ийг нэвтрүүлж, чөлөөт уран бүтээлч болон байгууллагыг бүртгэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах | Улсын болон орон нутгийн төсөв | Бүртгэлжүүлсэн уран бүтээлчдийн тоо | - | Эхний хагас жилд: 20-аас доошгүй уран бүтээлчийг бүртгэлжүүлсэн байна. Жилийн эцэст: 30-аас доошгүй уран бүтээлчийг бүртгэлжүүлсэн байна. | Монгол Улсын Соёлын яамнаас соёл урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангах цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй CREATIVEHUB цахим системд эхний хагас жилийн байдлаар 5 уран бүтээлчийг бүртгэлжүүлсэн ба гуравдугаар улиралд Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальтай уялдуулан уран бүтээлчдийг бүртгэлжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 5 уран бүтээлчдийг бүртгэлжүүлсэн. | 50% |
| 1.1.1.5 | "Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн системүүдийг орон нутагтаа нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах /номын сан, соёлын өв, GLAM, портал сайт/ | ОНТ | Мэдээллийн сангийн мэдээллийн хувь | - | Эхний хагас жилд: "Соёлын өв, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн санг 10 хувьд хүргэнэ. Салбарын портал сайт ашиглалт | Соёлын яамнаас цахим шилжилтийн хүрээнд салбарын статистикийн системийн хөгжүүлэлтийг дуусган хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын статистик мэдээ хариуцсан бүртгэлийн ажилтнуудад системийн сан бүрдүүлэх чиглэлээр дадлага ажил сургалтыг танхимаар зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулалаа.Музей, номын сангийн хэмжээнд хуучин ашиглагдаж буй цахим программ ашиглаж байгаагаас гадна шинээр хэрэгжиж буй номын сангийн КОХА системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP систем"-ийг салбарын 16 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлэн АЗДТГ-аас ERP системийн хэрэглээний талаарх сургалтыг 2 удаа авч сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглан албан ажилдаа хэрэглэж хэвшсэн.Соёл, урлагийн газар нь эхний хагас жилд ERP системээр 130 албан бичиг хүлээн авч, 84 албан бичиг бусад байгууллагад илгээж ажиллалаа. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ыг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлсэн байна." Жилийн эцэст: "Соёлын өв, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн санг 15 хувьд хүргэнэ. Салбарын портал сайт ашиглалтыг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлсэн байна." | хэрэгжилтийг хангах зорилгоор shilen.gov.mn цахим системд тайлант оны 06 дугаар сараас эхлэж бүртгэл үүсгэн нийтэд ил тод мэдээллэх мэдээллүүдийг оруулж хөгжүүлэлтийг хийхээр боллоо. Соёлын салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний moc.igovernment.mn цахим сан, Гүйцэтгэлийн удирдлагын moc.igovernment.mn систем болон Дорноговь аймгийн ХШҮ-ний dornogovi.unelgee.gov.mn цахим сангуудыг Соёл урлагийн газар болон 3 нэгж байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж, төлөвлөлт болон гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Албан хэрэгцээнд ашиглаж буй цахим системийн тоо -13 1. moc.igovernment.mn 2. plan.igovernment.mn 3. dornogovi.unelgee.gov.mn, 4. ХНУМТ 5. cis.mn 6. CREATIVEHUB 7. GLAM 8. ERP 9. АТГ-ын meduuleg. iaac.mn 10. няравын СТ программ 11. shilen.gov.mn 12. portal.moc.gov.mn 13. нягтлан бодох бүртгэлийн 7 программ auth.itc.gov.mn | |
| 1.2. | Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ | - | - | - | - | Нутгийн уран бүтээлчдийн “Түмэнд түгсэн дуун цадиг” тоглолтыг хамтран зохион байгуулж тоглолтод 25 нутгийн зохиолчийн бүтээл дэлгэгдэж, 25 уран бүтээлч оролцож танхимаар300 гаруй иргэд, цахимаар 4000 гаруй үзэж сонирхлоо. Зохиолч, судлаачдаа дэмжих зорилгоор Дэлгэрэх сумын Соёлын төвийн хөгжмийн багш Х.Болдбаатарын “Хуурч” номоос 10 ширхэг, МЗЭ-ийн Хурмаст тэнгэр төвийн гишүүн СГЗ Л.Эрдэнэбатын “Солонго эртний нутаг”,зохиолч Г.Бадамгэрэлийн “ Цалгих бодол” зохиолч Д. Бадамсүрэнгийн “Мөр” номоос тус бүр 5 ширхэгийг худалдан авч нээлтийн арга хэмжээнүүдэд оролцон СУГ-ын талархал, мөнгөн шагналаар шагнаж урамшуулан дэмжлэг үзүүллээ. Судлаач Н.Ганхуягийн “Монголын нууц товчоо”-ны дүн шинжилгээний хэлэлцүүлэг, ураг удам судлаач Д.Цогбадрахын хэлэлцүүлэг лекцэнд 86 сурагч оюутныг хамруулаа.МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Байгалмаа, яруу найрагч Т.Бадрах нарын шинэ ном хэвлэлтэд шилжлээ."Номын баяр"-2024 арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 1600 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачууд хамрагдлаа.Энэ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн "НОМЫН БАЯР"-ын арга хэмжээний хүрээнд ЕБС-н хүүхдүүдийн дунд “Олуулаа уншья” шүлгийн уралдаан, Бяцхан ерөөлч, Баримлаар урлахуй, "Монголын нууц товчоо- хэвлэлийн хуудаснаа" номын хэлэлцүүлэг,“Миний нандин эрдэнэ” захидлын уралдаан,Үндэсний хувцастай жагсаал, МУСГЗ яруу найрагч Л.Эрдэнэбат болон МЗЭ-ийн шагналт,Болор цомын эзэн яруу найрагч Д.Галсансүх нартай уншигч зохиолчдын уулзалт, Шинэ номын нээлт мөн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Монгол хэл, бичгийн үг үсэглэлийн" тэмцээн, зүйр цэцэн үг эвлүүлэх, монгол бичгээр унших ,англиар үг үсэглэх, номын хавчуурга урлахуй, сонсдог ном,шинэ шилдэг номын үзэсгэлэн,"Сайхан бичиг" "Уран бичвэр“-ийн үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион явууллаа.“Монгол гэр”соёлын орон зайг үүсгэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сургалт, угийн бичгийн сургалт, яруу найргийн open mic, Музейн боловсролын хөтөлбөр, хувийн сургалтын төвүүдийн тоглолт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 950 гаруй хүүхэд залуус хамрагдлаа. | |
| 1.2.2 .1 | Баяр наадам, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжих саналыг уламжлах | ОНТ | Арга хэмжээний тоо | 5 | Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 3 | Аймгийн хэмжээнд Жил бүр уламжлал болгон сар шинийн баярыг тохиолдуулан "Саран хөхөө" театр Олон-хүрээ Дэчинчойнхорлин хийд хамтран “Шашин урлагийн цэнгүүн” зохион байгуулж хэвшсэн бөгөөд энэ жил Саран Хөхөө театрын шинэ уран бүтээлийн дээжис тоглолдсноороо онцлог байлаа. Олон улсын Эмэгтэйчүүдийн баярт зориулж “Саран хөхөө” театрын уран бүтээлчид "БҮСГҮЙ ЕРТӨНЦ" хамтарсан тоглолт, уран бүтээлчдийн цэнгүүн, эх үрсийн баярт зориулсан хүүхдийн шинэ жүжиг зэрэг уран бүтээлийг үзэгч олондоо хүргэлээ. Олон улсын Эх хэлний өдөрт зориулан соёлын байгууллагын албан хаагчдын дунд "МОНГОЛ БИЧИГ БИДНИЙ БАХАРХАЛ" тэмцээнийг аймгийн төв номын сан амжилттай зохион байгуулж тэргүүн байранд Соёл урлагийн газар, дэд байранд Саран хөхөө театр тус тус шалгарлаа. Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ойг тохиолдуулан Зүүнбаянгийн Соёлын төв ордон уламжлалт "Цэрэг эрсийн дуулал-2024" цэрэг эх орны сэдэвт дууны уралдааныг зохион байгууллаа. Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвийн гишүүн “Утга зохиолын төлөө” шагналт яруу найрагч Ш.Баатарын “Шамбалын гэгээ” яруу найргийн номын нээлт, нутгийн уран бүтээлчдийн "Түмэнд түгсэн дуун цадиг" тоглолт, МУСГЗ Л.Эрдэнэбатын "Солонго эртний нутаг" номын нээлт, шилдэг бүтээлийн тоглолт, Дэлхийн бүжигчдийн өдрийг тохиолдуулан “Саран хөхөө” театрын гоцлол бүжигчин МУСТА Г. Оюунсүх МУСТА С. Мягмарсүрэн нарын хамтарсан “Хоёр ертөнц” бүжгийн тоглолт зэрэг тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийн тоглолт уралдаанууд боллоо. Үндэсний бичиг соёл номын баяр 2024 арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 1600 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачууд хамрагдлаа.12 сумд 100 жилийн ой тэмдэглэхтэй холбогдсон соёл, урлагийн бүхий л арга хэмжээнд болон сумын музейн шинэчлэл, номын сангийн стандарт зэрэгт мэргэжлийн байгууллагууд арга зүйн дэмжлэг үзүүлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Баяр наадам тэмдэглэлт ойд зориулсан 7 арга хэмжээг зохион байгууллаа.<br>Хавсралт: 4 файл | |
| 1.2.2.2 | Өв уламжлал ,хүмүүжлийн агуулгатай хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл туурвих | ОНТ 40.0 | Уран бүтээлийн тоо | 2 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1 | Өсвөр нас болон залуучуудад зориулсан МУСТА А.Баярсайханы зохиол найруулга "Хайрын гэрээ" уран сайхны шинэ киноны нээлт өдөрлөг боллоо. Кинонд аймгийн театрын уран бүтээлчид тоглосноос гадна зураг авалтын 70 % -ийг Сайншанд сумын Зүүнбаян багт авсан бүтээл болсноороо онцлог байлаа. Соёлын салбарын залуучуудын зөвлөл санаачлан МУСТА Н. Ундрахын удирдлага дор "Говийн уянга" хамтлагийн хүүхдүүдийн "Үзэсгэлэнт говь" бие даасан уран бүтээлийн тайлан тоглолтыг Сайншандчууддаа толилуулж том хүн хүүхэд нийт 1200 хүний хүртээл болголоо. Саранхөхөө театр Э.Нямдуламын зохиол “Эвт Мэргэн Өвгөн -Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд, мөн Э.Нямдуламын зохиол “Чандмань Эрдэнэ” хүүхдийн жүжгийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан шинэ уран бүтээлийг тайзнаа туурвилаа.Энэхүү хүүхдийн жүжгээр байгаль эх дэлхийгээ хайрлах, усны үнэ цэнийг мэдрэх, цаашлаад хүүхэд бүр байгальтайгаа зөв харьцах хайрлах үзэл бодлыг суулгах зорилготой ба говь нутгийн онцлог шингэсэн газар нутгийн шүтээн болсон амьтадын дүрийг гаргаж өгснөөрөө илүү онцлогтой юм.Нийт 7 удаагийн тоглолтоор 1067 үзэгчдэд толилууллаа“Т-энтертайнмент” студтэй хамтран 11 сумын соёлын төв гэрээний дагуу сар бүр 3-4 киног гаргаж 800 гаруй үзэгч багачуудад хамрагдлаа.нийт 7 удаагийн тоглолтоор 1067 үзэгчдэд толилууллаа. Замын-Үүд сумын Соёл спортын ордны Н.Төрбадрах багштай “Мини-Отголдой” хүүхдийн театр нь Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумын 950 хүүхдэд үе тэнгийн дээрэлхэл, зан байдал, харьцаа хандлага, хорт зуршлуудаас сэргийлэх сэдэвтэй сургамжит богино жүжигчилсэн тоглолтуудаар нөлөөллийн ажлуудыг хамтран хэрэгжүүллээ.Ноён хутагт Данзанравжаагийн намтар түүхээс сэдэвчилсэн богино хэмжээний телевизийн контентийг "DTV" телевизийн хамт олон цувралаар бүтээн олны хүртээл болголоо.<br>Хүрсэн түвшин: Уран бүтээлийн тоо 3<br>Хавсралт: 5 файл | 100% |
| 1.2.2.4 | Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг | ОНТ | Арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1 | Аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа-2" хөгжлийн хөтөлбөрт жил бүр энэхүү зорилт арга хэмжээг төлөвлөснөөр жил бүр өөрийн өвөрмөц онцлогтой олон талт ажлуудыг зохион байгуулсаар ирлээ. Энэ онд Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвийн 70 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан яруу найрагч, зохиолчидтой илүү хамтран ажиллаж байгаагаас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах | | | | | гадна Дорноговь аймгийн уугуул доктор Баатархүүтэй хамтран говь нутгийн соёлын өв, хайгуул, археологийн чиглэлийн судалгааны ажлууд, аймгийн 12 сумдын 100 жилийн ойтой холбоотой ном, судалгааны ажлуудыг хамтран хийлээ. Соёлын яамнаас зохион байгуулсан оны шилдэг уран бүтээлчийг шалгаруулах "Мөнгөн мод 2023" наадамд "Тэнгэрийн хутагт"" бүжгэн жүжгийн зохиолч нутгийн яруу найрагч Л. Эрдэнэбат, зураач Д.Ганпүрэв нарын материалыг шилдэг зохиолч, шилдэг зураачийн төрөлд нэр дэвшүүлэн дэмжиж ажиллалаа. Мөн сумдын соёлын байгууллагуудын албан хаагчдыг УБ хотноо тоглогдсон Говийн ноён хутагтын амьдрал уран бүтээлийг харуулсан түүхэн "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийг үзэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Нутгийн уран бүтээлчдийн " Түмэнд түгсэн дуун цадиг" тоглолтыг хамтран зохион байгуулж тоглолтод 25 нутгийн зохиолчийн бүтээл дэлгэгдэж, 25 уран бүтээлч оролцож танхимаар 300 гаруй иргэд, цахимаар 4000 гаруй үзэж сонирхлоо. Зохиолч, судлаачдаа дэмжих зорилгоор Дэлгэрэх сумын Соёлын төвийн хөгжмийн багш Х.Болдбаатарын "Хуурч" номоос 10 ширхэг, МЗЭ-ийн Хурмаст тэнгэр төвийн гишүүн СГЗ Л. Эрдэнэбатын "Солонго эртний нутаг", зохиолч Г. Бадамгэрэлийн " Цалгих бодол" зохиолч Д. Бадамсүрэнгийн "Мөр" номоос тус бүр 5 ширхэгийг худалдан авч нээлтийн арга хэмжээнүүдэд оролцон СУГ-ын талархал, мөнгөн шагналаар шагнаж урамшуулан дэмжлэг үзүүллээ. Судлаач Н.Ганхуягийн "Монголын нууц товчоо"-ны дүн шинжилгээний хэлэлцүүлэг, ураг удам судлаач Д.Цогбадрахын хэлэлцүүлэг лекцэнд 86 сурагч оюутныг хамрууллаа.Мөн МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Байгалмаа, яруу найрагч Т.Бадрах нарын шинэ ном хэвлэгдэн олны хүртээл боллоо.<br>Хүрсэн түвшин: Арга хэмжээний тоо 8<br>Хавсралт: 14 файл | |
| 1.2.2.5 | Олон улсын соёлын танилцуулга, хамтын ажиллагааны эскпо болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд театр, мэргэжлийн уран | ОНТ | Оролцогчдын тоо | - | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1 | МУСТА Б.Дашжаргал багштай "Majic dance" хүүхдийн бүжгийн клуб нь 12 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд БНХАУ-ын Хөх хот, Бээжин хотноо зохиогдсон 2 удаагийн олон улсын бүжгийн фестивальд 24 хүүхдийн бүрэлдэхүүнтэй оролцон тэргүүн байр эзэлсэн амжилт үзүүллээ. Сайншандын ЕБ-ын 2-р сургуулийн "Говийн уянга" бүжгийн хамтлаг нь Хэнтий аймагт болсон Санжаасүрэн агсны нэрэмжит улсын уралдаан, Соёлын яамнаас мэргэжлийн бүжгийн холбоотой хамтран зохион байгуулсан "Хүн домог" улсын уралдаанд амжилттай оролцон гранпри шагнал, Өмнөговь аймагт зохиогдсон "Өсвөрийн хөгжимчдийн улсын уралдаанд Сайншандын ЕБ-ын 5-р сургуулийн "Болор эгшиглэн" хөгжмийн хамтлаг оролцож тэргүүн байр эзэлсэн амжилтыг үзүүллээ. Боловсрол, Шинжлэх ухааны яам, Соёлын яамны дэмжлэгээр "Болор эгшиглэн" хөгжмийн хамтлаг Монголын хүүхдийн ордонд урилгаар хүрэлцэн очиж 2 удаагийн тоглолтоор нийслэлчүүддээ бэлэг барилаа.<br>Хүрсэн түвшин: Аймаг, бүс, улсын хэмжээний уралдаан наадмуудад өсвөрийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээлчид, хүүхэд залуучуудыг оролцуулах | | | | | авьяастнуудын оролцоо нэмэгдснээс гадна ЕБС-иудын дэргэдэх хамтлагуудаас гадна хувийн бүжгийн клубууд, "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлан, "Увидаст аялгуу" ятга хөгжмийн дугуйлан зэрэг урлагийн төрлийн хүүхэд хөгжлийн дугуйлан жил ирэх тусам нэмэгдэж, эцэг эхийн ойлголт, хандлага, хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх, урлагаар хичээллэхийн ач холбогдлыг жилээс жилд танин мэдсээр байна. | |
| 1.2.2.6 | Соёлын төвүүдийн дуу хөгжмийн багш, бүжгийн багш нарын ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | ОНТ | Хамрагдсан ажилтны тоо | - | Эхний хагас жилд: 10 Жилийн эцэст: 15 | Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.6, 4.1.3-т заасны дагуу Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэшсэн байдлын үнэлгээг 20%-аар нэмэгдүүлэх, зорилгоор СУИС-ын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран сумдын дуу хөгжмийн багш нарын ур чадварыг дээшлүүлж, чадавхжуулах 5 хоногийн сертифкат олгох кредит тооцох сургалтад Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Өргөн, Хөвсгөл, Эрдэнэ зэрэг 8 сумын хөгжмийн багш нарыг, бүжиг заах арга зүй 40 цагийн 6 хоногийн сургалтад 9 бүжгийн багшийг хамруулан Улаанбаатар хотноо зохион байгууллаа."Соёлын сэргэлт-2024" удирдах ажилтны зөвлөгөөн болон "Бүсчилсэн хөгжлийн бодлого" хэлэлцүүлэгт 14 сумын соёлын төвийн дарга, СУГ-ын удирдах ажилтан 3 албан хаагчийг хамрууллаа. Музейн үзүүллэг дэглэлт арга зүйн сургалтад 14 соёлын төвийн дарга 14 музейн ажилтан хамрагдлаа."Саран Хөхөө" театрт нэн шаардлагатай хөгжимчин мэргэжлээр СУИС-д 2023-2024 оны хичээлийн жилд 4 оюутныг 3 талт гэрээгээр аймгийн зардлаар захиалгаар сурган сургалтын төлбөрт 28,0 сая төгрөгийг шийдвэрлэлээ.2000-2024 оны хичээлийн жилд ЕБС-иудад дуу хөгжмийн багш мэргэжлээр бэлтгэгдэж байгаа оюутнуудын төлбөрийг үргэлжлүүлэн аймгаас санхүүжүүллээ.700 хүний суудалтай Саран хөхөө театрын шинэ барилга ашиглалтад орохтой холбогдуулан хөгжим, бүжгийн мэргэжлээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх, театрын хуучин барилгын ашиглалтыг хадгалан Сайншандад Соёлын ордон шинээр байгуулах, Замын-Үүд суманд 500 хүний суудалтай шинэ соёлын ордон ашиглалтад орохтой холбогдуулан урлагийн нарийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн зорилтот хөтөлбөр боловсруулан аймгийн Засаг даргад уламжиллаа.<br>Хүрсэн түвшин: Сумдын соёлын төвийн хөгжмийн багшийн 57%, бүжгийн багшийн 60% ийг кредит тооцох сертификаттай сургалтад хамрууллаа. | 90% |
| 1.2.2.7 | Өсвөрийн хөгжимчдийн аймгийн уралдаан зохион байгуулах | ОНТ | Арга хэмжээний тоо | - | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: - | Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрэл хайгуул хийн тус аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын дунд, ахлах насны хүүхэд багачууд, өсвөр үеийнхэнд Монгол үндэсний хөгжмийг таниулан сурталчлах, хөгжмөөр суралцах хичээллэх идэвхийг өрнүүлэх, театрын ирээдүйн хүний нөөц бүрдүүлэх, авьяаслаг хөгжимчдийг тодруулах, ЕБС-иудын хөгжмийн багш нарын идэвхийг өрнүүлэх олон зорилгыг өөртөө агуулсан нэгэн уралдааныг зарлан зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Саран хөхөө театртай хамтран "Авьяаслаг хөгжимчид" үндэсний хөгжмийн анхдугаар уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Сайншандад зохион байгууллаа. Уралдааныг гоцлол болон хамтлаг хөгжмийн төрлөөр зохион байгуулсан бөгөөд Сайншанд, Айраг, Дэлгэрэх, Замын-Үүд, Даланжаргалан, Зүүнбаян сумаас хамтлаг хөгжмийн төрөлд 12 хамтлаг, гоцлол хөгжмийн төрөлд 44 нийт 150 гаруй сурагчид оролцсон. Мөн Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газраас СУИС-ийн Хөгжмийн урлагийн их сургуульд 4 жилийн хугацаанд 3 талын гэрээгээр үнэ төлбөргүй сурах эрхийн бичгийг Замын-Үүд сумын сурагч Ж. Энхжин, Замын-Үүд сумын сурагч Г. Хүслэн, ЕБ-ын 5-р сургуулийн сурагч Ц.Түвшинбаяр нарт гардуулан өгсөн. Мөн "Шилдэг багш" шагналаар Сайншанд сумын ЕБ-ын 5-р сургуулийн хөгжмийн багш МУСТА Б.Баттайван шалгарлаа.Шилдэг хамтлагаар Замын-Үүд сумын 1-р сургуулийн хөгжмийн хамтлаг шалгарлаа.<br>Хүрсэн түвшин: Зохион байгуулсан уралдааны тоо -1<br><br>Хавсралт: 5 файл | |
| 1.2.2.8 | “Номын баяр” арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | УТ | Арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1 | УИХ-ын ивээл дор "Номын баяр -2024" арга хэмжээг аймгийн Төв Номын сан, Соёл урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Насан туршийн суралцахуйн төв, СӨБ болон ЕБ-ын сургуулиуд, АШУҮИС-ын салбар сургууль, Политехникийн коллеж, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв хамтран зохион байгууллаа. Мөн 14 сумын соёлын төвийн номын сан тус бүр сумандаа "Номын баяр-2024"арга хэмжээг өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоор зохион байгууллаа. "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд- 2024" номын баяр “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриан дор зохион байгуулагдаж баярын нээлтийн үеэр "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн" ЕБС-ын сурагч, анги хамт олныг шалгаруулллаа. "Номын баяр"-т аймгийн хэмжээнд нийт 1600 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачууд хамрагдлаа. Энэ удаагийн "НОМЫН БАЯР"-ын арга хэмжээний хүрээнд ЕБС-н хүүхдүүдийн дунд “Олуулаа уншья” аян, А.Эрдэнэ-Очирын шүлгийг уралдаан, Бяцхан ерөөлч, Баримлаар урлахуй, "Монголын нууц товчоо-хэвлэлийн хуудаснаа" номын хэлэлцүүлэг, “Миний нандин эрдэнэ” захидлын уралдаан, Үндэсний хувцастай жагсаал, МУСГЗ яруу найрагч Л.Эрдэнэбат болон МЗЭ-ийн шагналт, Болор цомын эзэн яруу найрагч Д. Галсансүх нартай уншигч зохиолчдын уулзалт, Шинэ номын нээлт мөн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Монгол хэл, бичгийн үг үсэглэлийн" тэмцээн, зүйр цэцэн үг эвлүүлэх, монгол бичгээр хэн хурдан унших вэ, англиар үг үсэглэх, номын хавчуурга урлахуй, сонсдог ном, төрөл бүрийн видео бичлэг, түргэн хэллэг, “АХА” танин мэдэхүйн тэмцээн, шинэ шилдэг номын үзэсгэлэн, "Сайхан бичиг" "Уран бичвэр“-ийн үзэсгэлэн зэрэг олон талт үйл ажиллагааг зохион явууллаа. Мөн ЕБС-ын сурагчдын урлагийн тоглолтыг иргэд, уншигч, хүүхэд багачуудад хүргэлээ. Хүүхдийн мэдлэг сорих, мэдлэг нэмэх үүднээс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танин мэдэхүйн ” АХА” тэмцээн, гар зургийн уралдаан, “Хутагтын бүтээлээс хэн ихийг мэдэх вэ” асуулт хариулт зохион байгуулж шалгарсан хүүхдүүдэд үлгэрийн ном бэлэглэлээ.Энэ удаагийн номын баяраар "Монгол гэр-Соёлын орон зай" -тай 8 ханатай гэрт үзэсгэлэн гаргаснаараа онцлог боллоо.<br>Хүрсэн түвшин: Хаврын "Номын баяр" арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан 1600 гаруй иргэн, хүүхэд багачууд хамрагдлаа.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.2.2.9 | “Соёлын орон зай”, “Соёлын бүтээлч сар” зорилтот арга хэмжээг зохион байгуулах | ОНТ | Арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2 | "Соёлын сэргэлт 2024” аяны хүрээнд зохион байгуулсан “Гэр” үзэсгэлэнд “Ноён хутагтын өргөө” халх угсаатны 8 ханатай гэрийг бүтээн Улаанбаатар хотноо 9 хоног соёлын орон зай үүсгэн сурталчлан таниуллаа. Гэрийн сийлбэрт нутгийн онцлогийг тусган урчуудын эвлэлийн гишүүн Л.Халзан зураачийн эх бэлтгэлээр Хилэнц, 12 жил, Тэмээ- Буур, Дорноговь аймгийн лого зэргийг сийлбэрээр тодотгон бүтээлээ. Үзэсгэлэнгийн үеэр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей болон аймгийн МССТ хамтран “ Монгол гэр” “ Барлах урлаг” “ Монгол гэрийн дүрслэл” зэрэг 3 боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2000 гаруй иргэд, хүүхэд багачуудыг хамрууллаа. Үзэсгэлэнгийн гэр бүтээхэд Соёлын яамнаас 30 сая төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Гэрийн зураг дүрслэл, хээ угалзыг Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач МУСТА Л. Халзан, гэрийн эдлэл хэрэгсэл Хутагтын хөрөг ,3 шүтээн болон, Хамрын хийд, хайрханы зургуудыг политехникийн коллежийн багш Б.Түвшинтөр нар бүтээсэн. Аймгийн засаг даргын дэмжлэгээр аймгийн төв цэцэрлэгт хүрээлэнд соёлын орон зай үүсгэн тоног төхөөрөмж , тайз бүхий орчин бүрдүүлэн соёлын орон зайд эртэч өглөө, open mic, Үндэсний хөгжмийн "Болор эгшиглэн" хамтлагийн тайлан тоглолт, "Эгшиглэн энтертаймент" сургалтын төвийн тайлан тоглолт гэх мэт арга хэмжээнүүд зохион байгуулж хүүхэд залууст хүргэлээ. Мөн “ Монгол гэр” соёлын орон зайг үүсгэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сургалт, / саван, лаа, нэхмэл хийх гэх мэт / шатар, даам, угийн бичгийн сургалт, яруу найргийн open mic, уншигч зохиолчдын уулзалт, Музейн боловсролын хөтөлбөр, хувийн сургалтын төвүүдийн үйл ажиллагааг сурталчилсан тоглолт үзүүлбэрийг 5 дугаар сарын 21ний өдрөөс 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулж 950 гаруй хүүхэд залуусыг хамруулан соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.Өргөн сумын Соёлын төвөөс 4-р сарыг "Бүтээлч сар" болгон 4 том хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.<br>Хүрсэн түвшин: Хагас жилийн байдлаар бүх нийтийн соёлын боловёролыг дээшлүүлэх зорилготой соёлын орон зайг үүсгэн 1 нөлөөллийн ажил, 2 томоохон арга хэмжээг зохион байгууллаа. | 100% |
| 1.2.2 | Соёлын | ОНТ | Бичиг | 2 | Эхний | Салбарын нийт байгууллагуудыг үндэсний бичгийн булантай болох үүрэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| .10 | төвүүдэд үндэсний бичгийн булан байгуулах, Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлах, монгол бичгээр дагнасан үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах “Бүх нийтээрээ хос бичигтэн” болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах | | үсгийн дурсгалд холбогдох баримтат өвийн бүртгэл гаргах, ”Үндэсний бичиг үсгийн баяр-2023” “Эх хэлний өдөр-2023” арга хэмжээг зохион байгуулах | | хагас жилд: 1 Жилийн эцэст: 2 | чиглэл өгснөөр Иххэт, Зүүнбаян, Хатанбулаг, Эрдэнэ, Даланжаргалан, Мандах, Хөвсгөл сумдууд болон СУГ, үндэсний бичгийн буланг байгуулан ажиллалаа. Хагас жилийн байдлаар 8 байгууллага үндэсний бичгийн булан байгуулан хос бичгээр мэдээ мэдээллийг албан хаачдад хүргэн ажиллаж байна. "Эх хэлний өдөр"-ийг тохиолдуулан аймгийн Төв номын сангаас үндэсний бичгийн уралдааныг салбарын хэмжээнд зохион байгуулж СУГ-ын баг хамт олон тэргүүн байр эзэлсэн. Насан туршийн суралцахуйн төв, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ЕБ-ын 12 дугаар ангийн сурагчдын дунд "Тунгаамал" үндэсний бичгийн уралдааныг зохион байгуулж 36 сурагч хамрагдаж ЕБ-ын 5-р сургуулийн сурагчид тэргүүн байр эзэллээ. Энэ үеэр сургуулиуд үндэсний бичиг, уран бичвэр, таталган бичгийн үзэсгэлэн гаргалаа. Аймгийн төв номын сан МССТ -ийн 23 албан хаагч үндэсний бичгийн сургалтад хамрагдахаас гадна аймгийн төвийн соёлын байгууллагууд нь мэдээллийн самбарыг хос бичгээр хөтлөн явуулж хэвшлээ. Төрийн албан хаагчдын дунд “ Тунгаамал” “ Үсэглэлийн хаад” тэмцээнийг Насан туршийн суралцахуйн төв, БШУГ-тай хамтран зохион байгуулж Стандарт хэмжил зүйн хэлтэс, ШШГГазар, ЭМГазар, 8-р цэцэрлэг, 12 дугаар цэцэрлэгийн 5 баг оролцлоо. Мөн “ Үсэглэлийн хаад” тэмцээнийг аймгийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж 20 гаруй байгууллагын 78 албан хаагчийг хамруулан зохион байгуулж бүх нийтээр хос бичигтэн болоход уриаллаа.<br>Хүрсэн түвшин: Хагас жилийн байдлаар аймгийн соёлын 17 байгууллагаас 8 сумын соёлын төв Соёл, урлагийн газар үндэсний бичгийн буланг байгуулан ажиллалаа.<br>Хавсралт: 7 файл | |
| 1.2.2.11 | Соёлын төв, ордныг түшиглэсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлж, брэнд болгон хөгжүүлэх | ОНТ | Брэнд бүтээгдэхүүнтэй сумдын тоо | - | Эхний хагас жилд: Брэнд бүтээгдэхүүнтэй сумдын тоо нэмэгдэж ,соёлын төвийг түшиглэсэн аялал жуулчлал хөгжиж эхэлсэн | Соёл, урлагийн байгууллагууд шинэлэг олон талт ажлуудыг төлөвлөн хэрэгжүүллээ.Монголын Зохиолчдын "Хурмаст тэнгэр төв"-ийн 70 жилийн ой угтсан ном хэвлэл, утга зохиолыг сурталчилсан цуврал арга хэмжээ явагдаж 5 зохиолч, яруу найрагч шинэ номын баяр хийснээс гадна Иххэт суманд хичээллэсэн "Өвлийн байшин" утга зохиолын дугуйлангийн сурагчдын "Тавдугаар сар" шүлгийн ном уншигчдын гарт очлоо. "Түмэнд түгсэн дуун цадиг", Орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнгийн үеэр Занабазарын нэрэмжит дүрсллэх урлагийн музейтэй хамтран 3 боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж 1700 гаруй иргэнийг хамруулж 9 хоногийн турш тус үзэсгэлэнг 10,000 гаруй иргэд үзэж сонирхлоо. Аймгийн музей, сургалт судалгааны төвөөс "Музейтэй Дорноговь" 1 сарын аяныг өрнүүлж "Өвлөн уламжлагчдын тоглолт", Шог зураач Р.Гал-Одын шог зургийн үзэсгэлэн, "Мөнгөн тэмдэгт зоосон мөнгө", "Metal art" зэрэг 8 үзэсгэлэнг зохион байгуулж 3200 гаруй иргэн үзэж сонирхлоо. Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачуудад сурталчлан мэдлэг олгох зорилгоор Соёл урлагийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. Жилийн эцэст: Брэнд бүтээгдэх үүнтэй сумдын тоо нэмэгдэж ,соёлын төвийг түшиглэсэн аялал жуулчлал хөгжиж эхэлсэн байна. | газраас төрийн болон хувийн хэвшлийн байгууллага клубуудтэй хамтран "Монгол гэр-Соёлын орон зай" соёлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж 10 хоногийн турш өдөр бүр өөр өөрийн онцлог бүхий өв соёлоо сурталчилж 500 гаруй иргэдэд хүргэлээ. Мөн номын баяр болон монгол гэр соёлын хөтөлбөрийн хүрээнд яруу найргийн OPEN MIC арга хэмжээг монгол гэрт зохион байгуулж оролцогчид өөрсдийн зохиосон болон хүндэлдэг яруу найрагчийн дуртай шүлгүүдээ уншиж сонордууллаа.Сайншандын 10-р цэцэрлэгтэй хамтран "Монгол бахархлын өдөр" арга хэмжээг Монгол гэрт хийж СӨБ-ийн 115 хүүхэд хамрагдлаа.Сумдын 100 жилийн ой угтсан Эрдэнэ сумын авьяастнуудын болон Өргөн сумын "Мөнгөн харш" хүүхдийн хамтлагийн, Замын-Үүд сумын "Мини -Отголдой" хүүхдийн театрын аялан тоглолтууд өөрийн аймгийн сумдад үйлчлэн 2586 хүүхэд, 2650 том хүнд үйлчиллээ.<br>Хүрсэн түвшин: Арга хэмжээний тоо-13 Үйлчилгээ авсан иргэдийн тоо 15400 | |
| 1.2.2.12 | Сумдын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах соёлын олон талт арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх | ОНТ | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "5-аас доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна." | Тус аймгийн 11 сумд 100 жилийн ойтой бөгөөд тэдгээр сумдын музейг шинэчлэх, үзүүллэг дэглэлтийг өөрчлөх, номын санг стандартын дагуу тохижуулах, Иххэт, Алтанширээ сумын Соёлын төвийн урсгал засвар, Өргөн, Замын-Үүд сумдын тоног төхөөрөмжийн шинэчлэл, сумдын Соёлын төвийн дарга нар, хөгжмийн багш, бүжгийн багшийг чадавхжуулах зэрэгт Соёл, урлагийн газрын зүгээс болон аймгийн МССТ, Төв номын сан, Орон нутгийн өмчийн алба мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Ой угтсан олон талт соёлын ажлууд, ардын авьяастнуудын дундах уралдаан наадам, Өргөн сумын "Мөнгөн харш" хүүхдийн хамтлагийн аялан тоглолт, Эрдэнэ сумын ардын авьяастнуудын аялан тоглолт хийхэд дэмжлэг үзүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Сумдын 100 жилийн ойг угтан Соёл, урлагийн салбарт онцгой амжилт гаргасан болон тогтвор суурьшилтай ажиллаж буй ажилтнуудыг салбарын болон төр засгийн одон медиалаар шагнуулахаар 24 хүний шагналын тодорхойлолтыг хүлээн авч хянан дээд шатны байгууллагад уламжиллаа.<br>Хүрсэн түвшин: Соёлын яам байгуулагдаж бодлогын түвшинд үсрэнгүй амжилт үзүүлсээр ирлээ. "Соёлын сэргэлт-2024" аяны хүрээнд Занабазарын нэрэмжит "Дүрслэх урлагийн музей"-тэй хамтран мэргэжлийн түвшинд сумдын Соёлын төвүүдийн албан хаагчдыг чадавхжуулах, музейн боловсролын хөтөлбөрүүдтэй болохын ач холбогдлыг иргэд, сум орон нутгийн удирдлагад ойлгуулсан олон талт ажлууд зохиогдлоо. Үр дүнд суурилсан санхүүгийн системтэй болсноор Соёлын яамны бодлогыг анхан шатны нэгж байгууллагууд шат шатандаа хэрэгжүүллээ. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2.14 | Түүхэн сэдэвт болон хүүхдэд зориулсан монгол кино бүтээлийн үзвэрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг нийт сумдын соёлын төвийг түшиглэн зохион байгуулах | ОНТ | Үзэгчдийн тоо | - | Эхний хагас жилд: Сум бүрт кино үзвэрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. Жилийн эцэст: Сум бүрт кино үзвэрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. | Соёлын яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу бүх нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор сумдын соёлын төвүүд "Тэнгэрлэг гурван түвшин" ХХК-ны дэргэдэх "Т-энтертайнмент"-тай хамтран ажиллах гэрээ байгуулснаар 7 хоног тутам сумын иргэд олон нийт, хүүхэд багачуудад шинэ киног хүргэж ажиллалаа. Аймгийн хэмжээнд нийт 11 сумын соёлын төв гэрээний дагуу сар бүр 3-4 киног гаргаж 800 гаруй иргэнд дэлгэцийн урлагийн соёлыг түгээж үйлчилсэн нь томоохон төв суурин газрын соёлын үйлчилгээг орон нутгаас авах боломжийг бүрдүүлсэн. Сайншанд хотод үйл ажиллагаагаа явуулдаг “Gobi cinima” кино театр нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 32 киног 7044 иргэнд хүргэж үйлчиллээ. Үүнээс 10 Монгол киног 4195 хүнд хүргэсэн.<br>Хүрсэн түвшин: Т. энтертаймент ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж кино урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх мөн кино үзвэрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн | 90% |
| 1.2.2.14 | Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулж, тухайн орон нутгийн бүх шатны байгууллага, хувийн хэвшил, ТББ, иргэдийг уриалах | ОНТ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, нөлөөллийн аяны тоо | - | Эхний хагас жилд: 10-оос доошгүй арга хэмжээ, 1-оос доошгүй нөлөөллийн аян зохион байгуулах Жилийн эцэст: 10-оос доошгүй арга хэмжээ, 1-оос доошгүй | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Соёлын сайд, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын хамтарсан " Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх" нөлөөллийн цогц ажлуудыг зохион байгуулах 2023 оны 12 дугаар сарын 05-ны албан даалгавар, Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан "Бүх нийтийн соёлын боловсрол" тушаалын хэрэгжилтийг хангаж бүх нийтийн соёлын боловсролын төлөвлөгөөг сар бүр боловсруулан нэгж байгууллага болон сумдын соёлын төвүүдэд хүргэж ажилласан.БШУГ-тай хамтран сар бүрийн сүүлийн ажлын өдрийг “Соёлын өдөр” болгон зарласан бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө гарган БШУГ, СУГ-ын дарга нар батлан боловсрол, соёлын байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн нийт ЕБС болон СӨБ-ын байгууллагаууд сар бүрийн сүүлийн өдөр хүүхдэд соёлын боловсрол олгох угийн бичгийн сургалт, чөлөөт хувцасны өдөр, үндэсний өв соёлыг сурталчлах уртын дуу, морин хуур, бий биелгээний сургалт өдөрлөг зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.МССТ-өөс “Дээлтэй Монгол” “Би зураач” “Гэр” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн музейн боловсрол олгож 113 хүүхдийг хамрууллаа. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд 05 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал аймгийн төв талбайд “Монгол гэр” соёлын орон зай үүсгэн Үндэсний бичгийн үзэсгэлэн, цахим бичвэрийн сургалт,Соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нөлөөллийн аян зохион байгуулах | бүтээлч үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн сургалт, МССТ-ийн боловсролын хөтөлбөрүүд, угийн бичгийн сургалт, яруу найргийн open mic, соёлын өвийг сурталчилах арга хэмжээ, хүүхэд хөгжлийн дугуйлангуудын нээлттэй өдөрлөг, яруу найрагч Галсансүхтэй хийсэн уншигч, зохиолчийн уулзалт соёл урлагийн чиглэлээр аймагт үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг сурталчлах зэрэг 21 цогц арга хэмжээнүүдийг иргэдэд нээлттэй зохион байгуулж 950 гаруй иргэн хүүхэд багачуудыг хамруулллаа.<br>Хүрсэн түвшин: Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд " Монгол гэр" нөлөөллийн аян, 20 гаруй арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. | |
| 1.2.15 | Соёл, Урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих | ОНТ | Орон нутагт шилжин суурьших ад орон сууц бусад дэмжлэг сургалт | 2023 онд нийт 9 соёлын ажилтныг орон сууц ажиллах орчин нөхцлөөр хангасан. | Эхний хагас жилд: -Жилийн эцэст: Орон нутгийн Соёлын байгууллагад хотоос шилжин суурьшиж ажиллах иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна. | Орон нутагтаа хөгжмийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор Аймгийн Засаг даргын дэмжлэгээр СУИС-д 4 оюутантай гэрээ байгуулан 28,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган дэмжлэг үзүүлэн суралцуулж байна. Мөн орон нутгийн Соёлын төвд шилжин суурьшиж ажиллаж байгаа 5 албан хаагчыг төрийн албан хаагчын байранд ая тухтай орчинд хөнгөлөлттэй нөхцөлөөр амьдруулж байна. Саран хөхөө театрын үйл ажиллагааг сайжруулах, тэгш хүртээмжтэй хүргэх, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор оюутан залуустай уулзалт арга хэмжээг зохион байгуулснаар бүжгийн багш томилон ажиллуулж байна. Тухайн багшийн нийгмийн баталгаа, суурьшин амьдрахад дэмжлэг үзүүлж төрийн албан хаагчдын байранд хөнгөлөлттэй нөхцөлөөр амьдрууллаа. “Саран хөхөө” театрт Улаанбаатар хотоос дуучин МУСТА Б.Жавхлантөгс, бүжигчин Ц.Золжаргал, Сайхандулаан сумаас Э.Балжинням шилжин ирж ажиллаж байгаа бөгөөд шилжин суурьшиж ажиллаж байгаа албан хаагчдын амьдрах орчин нөхцөл нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр аймгийн Засаг даргад уламжлан ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор Соёл Урлагийн Их сургуулийн хөгжмийн ангид суралцаж байгаа оюутнуудтай төгсөөд ирж ажиллах гэрээг байгуулан орон нутгаас сургалтын төлбөрийг бүрэн хариуцаж ажиллаж байна. Мөн Орон нутагт шилжин суурьшиж ажиллаж байгаа 5 албан хаагчын амьдрах орчины нийгмийн асуудлыг шийдвэрлэж өгсөн ба Саран хөхөө театрт шилжин ирж ажиллаж байгаа 3 албан хаагчын нийгмийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэхээр аймгийн Засаг даргад уламжилсан.<br>Хавсралт: 4 файл | 100% |
| 1.3. | Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, | - | - | - | - | Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллого зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар захирамжаар аймгийн Соёл урлагийн газрын даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй батлууллаа.Тооллогын комисс 2 удаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалалтыг сайжруулан, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна | | | | | хуралдсан бөгөөд шаардагдах зардлын төсвийг хэлэлцэн бэлэн болголоо. Монгол гэрийн уламжлалт урлал биет бус өвийн зан үйлийг сурталчлах зорилгоор Соёлын яамнаас зохион байгуулсан “Монгол-гэр” үзэсгэлэн арга хэмжээнд оролцож уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээлийг 9 хоногийн турш Улаанбаатар хотын төв талбайд 10000 гаруй хүндсурталчлан алдаршууллаа. Тус арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.Монгол улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан "Музейтэй Дорноговь" сарын аяны аяны хаалтын арга хэмжээнд музейн дэргэдэх МУСТА уртын дуучин Ч.Цэрэндэжид багштай “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, А.Энхнаран багштай “Увидаст ятга” ятгын дугуйлангийн суралцагчид болон ерөөлч магтаалч өвлөн уламжлагчдын ардын язгуур урлагийн тоглолтыг “Саран хөхөө” театрт зохион байгууллаа.Тус дугуйлан нь 2014 оноос эхлэн Монгол ардын уртын дууны шавь сургалтын үйл ажиллагаагаа явуулан, 10 жилийн хугацаанд 300 гаруй шавь төрүүлсэн. Өвлөн уламжлагчдаас Соёлын яамны "Тэргүүний ардын авьяастан" цол тэмдгээр шагнуулахаар 10 хүний материалыг хүргүүллээ. "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д бүртгэгдсэн Сайхандулаан сумын нутагт орших "Хар хөтлийн палеонтлогийн дурсгалт газар"-ыг хариуцан хамгаалуулах гэрээг 3-р багийн иргэн Д.Төмөрбаатартай, Мандах сумын нутаг дэвсгэрт орших "Сүйхэнтийн палеонтлогийн дурсгалт газар"-ыг Өлгий хийдийн хамба ламд, Улаанбадрах сумын Баянбогд хайрханы ойролцоох газрыг Ш.Гомбодоржид хариуцуулан гэрээ байгуулж, улсын хамгаалалт бүхий 6 үл хөлдлөх дурсгалыг иргэдэд 100% гэрээгээр хариуцуулан хамгаалууллаа. | |
| 1.3.3 .1 | Музейн сан хөмрөг буюу хөдлөх дурсгалын улсын тооллого, баримтат өвийн бүртгэлийг зохион байгуулах, тайлагнах | ОНТ | Хийгдсэн байх | Үзмэрийн тоо- 5668 | Эхний хагас жилд: Үзмэрийн тоо- 2668 Жилийн эцэст: Үзмэрийн тоо- 3000 | Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллого зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар захирамжаар аймгийн Соёл урлагийн газрын даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй батлууллаа.Тооллогын комисс 2 удаа хуралдсан бөгөөд шаардагдах зардлын төсвийг хэлэлцэн бэлэн болголоо. Хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан улсын хэмжээнд тооллого хойшилсон тул нэгдсэн удирдамж, шийдвэрийг хүлээсэн байдалтай ажиллалаа.Баримтат өвийн бүртгэлийг сум тус бүр 100 жилийн ойтойгоо холбогдуулан шинэчлэн гаргалаа.<br>Хүрсэн түвшин: Хугацаа болоогүй. Тооллогын бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.<br>Хавсралт: 1 файл | 50% |
| 1.3.3 | Соёлын биет бус өвийг өвлөн | ОНТ | Арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: 1 | Монгол гэрийн уламжлалт урлал биет бус өвийн зан үйлийг сурталчлах зорилгоор Соёлын яамнаас зохион байгуулсан “Монгол-гэр” үзэсгэлэн арга хэмжээнд оролцож уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээлийг 9 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уламжлагчдын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, алдаршуулах | | | | Жилийн эцэст: 1 | хоногийн турш Улаанбаатар хотноо 10,000 гаруй иргэнд сурталчлан алдаршууллаа. Тус арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.Монгол улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан "Музейтэй Дорноговь" сарын аяны аяны хаалтын арга хэмжээнд музейн дэргэдэх МУСТА уртын дуучин Ч.Цэрэндэжид багштай “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, А.Энхнаран багштай “Увидаст ятга” ятгын дугуйлангийн суралцагчид болон ерөөлч магтаалч өвлөн уламжлагчдын ардын язгуур урлагийн тоглолтыг “Саран хөхөө” театрт зохион байгууллаа.Тус дугуйлан нь 2014 оноос эхлэн Монгол ардын уртын дууны шавь сургалтын үйл ажиллагаагаа явуулан, 10 жилийн хугацаанд 300 гаруй шавь төрүүлсэн. Өвлөн уламжлагчдаас Соёлын яамны "Тэргүүний ардын авьяастан" цол тэмдгээр шагнуулахаар 10 хүний материалыг хүргүүллээ.Соёл урлагийн газраас хэрэгжүүлсэн "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт соёлын биет бус өвийн уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадам, уриа дуудлагын ай савын төрлүүд болох монгол шатрын тоглоом наадгай, шагайн харваа болон "Найрын дэг ёс" -ийг танилцуулан шатар болон шагайн холбоод, өвлөн уламжлагч нартай хамтран ажиллалаа.Иххэт сумын соёл, спортын төвөөс үндэсний шагайн харвааны тэмцээн, морь бөхийн цол дуудах бүсийн уралдаан зэрэг соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэн сурталчлах 2 удаагийн арга хэмжээ, Хатанбулаг сумын соёл, спортын төвөөс өвлөн уламжлагч Д.Лувсанбалдангийн аман хууч яриагаар үлгэрийн контент бүтээлгэж алдаршуулан олон нийтэд сурталчилж ажилласан.Замын-Үүд сумын шагайн холбооноос санаачлан тус сумын ЗДТГ, Соёл, спортын ордон хамтран сумын 30 жилийн ойг угтан “Шагайн харваа-2024” тэмцээнийг аймгийн 6 сумдын 14 багийн 112 харваачдын дунд зохион байгууллаа.<br>Хүрсэн түвшин: Тайлант оны хагас жилийн байдлаар соёлын салбарын хүрээнд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдыг алдаршуулах улсын 1, аймаг бүсийн 4, сум орон нутгийн хэмжээний 2 буюу нийт 7 үйл ажиллагаа, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.<br>Хавсралт: 19 файл | |
| 1.3.3.3 | Музейн сан хөмрөгийг баяжуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтыг | ОНТ | Сан хөмрөгийн баяжилт Үл хөдлөх дурсгалт газрын | Сан хөмрөгийн баяжилт 10 Бүртгэлжүүлсэн үл хөдлөх дурсгалт | Эхний хагас жилд: Сан хөмрөгийн баяжилт 3 Бүртгэлж | Тайлант оны хагас жилийн байдлаар Музей, сургалт судалгааны төв нь Замын -Үүд сумын гаальд хураагдсан түүх соёлын дурсгалт зүйлсийг Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэврээр 35 судар номыг баримтат өв болон музейн сан хөмрөгт бүртгэснээс гадна Айраг, Улаанбадрах, Дэлгэрэх, Өргөн сумдын орон нутаг судлах музей чулуун эд хэрэгсэл, хөгжмийн зэмсэг зэрэг, 15 ширхэг үзмэрээр сан хөмрөгийн баяжилт хийлээ. Улаанбадрах сумаас баруун тийш 35 км-т орших гөрөөсний дүрслэл бүхий хадны зураг, Дэлгэрэх сумын нутаг дэвсгэрт орших Нүдэнгийн хийдийн туурь, Гурван гашууны шүү зэрэг нийт 3 үл хөдлөх дурсгалт газрыг бүртгэлээ. Музей | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах | | тоо | газрын тоо 2 | үүлсэн үл хөдлөх дурсгалт газрын тоо 1 Жилийн эцэст: Сан хөмрөгийн баяжилт 7 Бүртгэлж үүлсэн үл хөдлөх дурсгалт газрын тоо 1 | сургалт, судалгааны төв, Иххэт сумын соёл, спортын төвөөс Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран чулуун арслан, хүн чулуу хөшөө зэрэг 1 хөдлөх дурсгал, 1 үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлууллаа<br>Хүрсэн түвшин: Сан хөмрөгийн баяжилт-35 ном судар, 1 иж бүрдэл, 15 ширхэг үзмэр Шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгал-1, үл хөдлөх дурсгалт газар-2 Сэргээн засварласан дурсгал-2 | |
| 1.3.3.4 | Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг болон баримтат өвийг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулна. | ОНТ | 15-аас доошгүй уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг сурвалжлан олж бүртгэсэн байна. | Соёлын хөдлөх өвийн улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан | Эхний хагас жилд: Орон нутагт бүртгэн баримтжуулах ажил зохион байгуулсан байна Жилийн эцэст: Орон нутагт бүртгэн баримтжуулах ажил зохион байгуулсан байна | Иргэд олон нийтэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах зорилгоор Үндэсний сургагч багш , өв соёл ураг удам судлаач Д.Цогбадрах, хүний их эмч Александр нартай хамтран "Угийн бичиг-Улсын үндэс" хөтлөх номын жишиг танилцуулах, мэдээлэл өгөх сургалт арга хэмжээг "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт тусган хэрэгжүүллээ. Тус сургалтыг 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж 50 гаруй иргэнийг хамрууллаа. Иххэт, Сайхандулаан, Хөвсгөл сумдын соёл болон соёл, спортын төвөөс угийн бичиг хөтлөх арга зүйн 4 удаагийн танхимын сургалт зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 111 сурагч 6 залуу гэр бүлийг хамрууллаа. 2022-2024 онуудад угийн бичиг хөтлөх 117 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулж угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2056 болсон байна.Энэ нь тус аймгийн өрхийн 21% -ийг эзлэж байгаа билээ. Аймгийн Насан туршийн боловсролын төв болон сумдын музейн ажилтнууд, ЕБС-иудын насан туршийн боловсролын багш нартай хамтран арга зүйн сургалтуудыг жил дараалан 3-4 удаагийн давтамжтай мэдээллийг түгээн ажиллалаа. СУГ цаашдаа аймгийн ЗДТГ болон сумдын Засаг дарга нарын идэвхи санаачилгыг өрнүүлэх талаар сүүлийн хагас жилийн гүйцэтгэлд анхааран ажиллахаар боллоо.Замын-Үүд сумын иргэн Ганпүрэвийн гар дээр хадгалагдаж буй Боржигон овогт Сандагдоржийн угийн бичиг, Н.Баатархүүгийн гар дээр хадгалагдаж буй Хутагт боржигин овогт Өвгөний Тавхайн удмын угийн бичгийг тус тус баримтат өвд бүртгэн баримтжууллаа.Сайншанд, Хатанбулаг, Иххэт, Алтаншираэ, Даланжаргалан сумдад 10 уламжлалт хуучны аргаар хөтөлсөн угийн бичгийн бүртгэлийг хийлээ.<br>Хүрсэн түвшин: Тайлант оны хагас жилийн байдлаар угийн бичиг хөтлөх арга | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүй ач холбогдолыг таниулах зорилгоор нийт 6 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулж 160 гаруй иргэн, 6 залуу гэр бүлийг хамруууллаа.Гэр бүл рүү чиглэсэн арга хэмжээнүүд дутуу явагдаж байна гэж дүгнэлээ. Сумдын Засаг дарга нарын үүргийг нэмэгдүүлэх, угийн бичгийн талаар аймгийн зөвлөгөөн хийж идэвхжүүлэх шаардлага байна гэж үзлээ.Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичгийн бүртгэлийн тоо-12<br><br>Хавсралт: 8 файл | |
| 1.3.4 | Аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулна. | ОНТ | Гэрээний тоо | 3 | Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 5 | Засгийн газрын 13-р тогтоолоор батлагдсан "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д бүртгэгдсэн Сайхандулаан сумын нутагт орших "Хар хөтлийн палеонтлогийн дурсгалт газар"-ыг хариуцан хамгаалуулах гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр нэг талаас тус сумын Соёлын төвийн дарга М.Тогтохбаяр нөгөө талаас 3-р багийн иргэн Д.Төмөрбаатар нар харилцан тохиролцон байгууллаа. Мөн жагсаалтад бүртгэгдсэн Мандах сумын нутаг дэвсгэрт орших "Сүйхэнтийн палеонтлогийн дурсгалт газар"-ыг ойролцоо орших Өлгий хийдээс гэрээт бусаар харж хамгаалдаг байсан бөгөөд тус сумын Соёлын төвөөс Өлгий хийдийн хамба ламд хариуцуулан хамгаалуулах гэрээ байгуулж тус аймгийн хэмжээнд улсын хамгаалалт бүхий 6 үл хөлдлөх дурсгалыг иргэдэд 100% гэрээгээр хариуцуулан хамгаалууллаа. Улаанбадрах сумын аймгийн хамгаалалт бүхий үл хөдлөх дурсгал газар болох Баянбогд хайрханы ойролцоох газрыг багийн иргэн Ш.Гомбодоржд хариуцуулан гэрээ байгууллаа.<br>Хүрсэн түвшин: Шинээр байгуулсан гэрээний тоо-3<br><br>Хавсралт: 2 файл | 90% |
| 1.3.3.6 | “Урланд ирсэн намар” яруу найраг, уран зургийн хосолсон катологи хэвлүүлэх | ОНТ | каталоги гаргасан байх | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Дорноговь аймгийн яруу найрагчид буюу Монголын зохиолчдын "Хурмаст тэнгэр" төвийн гишүүд, зураач урчуудын "Их дөмөн" холбооны гишүүд зураачдын хамтарсан "Урланд ирсэн намар" үзэсгэлэнгийн бүтээлээр товхимол хэвлүүлэх ажлын бэлтгэл хангагдлаа. Энэ онд "Хурмаст тэнгэр" төвийн 70 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан аймгийн орон нутгийн музейгээр үйлчлүүлж буй "Хамарын хийд-Ханбаянзүрх хайрхан" чиглэлд дотоодын аялал жуулчлал хийж буй иргэдийн гарт уг товхимолыг хүргэснээр нутгийн зохиолч найрагчид, зураачдын бүтээлийг сурталчлах түгээх ач холбогдолтой билээ.Шаардагдах төсвийн тооцоог хийж орон нутгийн төсвөөс дэмжлэг авахаар боллоо.<br>Хүрсэн түвшин: Эх бэлтгэлийг дуусгалаа. | 50% |
| 1.3.3.7 | "Дорноговь судлал" эрдэм | ОНТ | арга хэмжээни | - | Эхний хагас | Хугацаа болоогүй | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээний хурал | | й тоо | | жилд: - Жилийн эцэст: 1 | Хүрсэн түвшин: - | |
| 1.3.4 | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох | УТ, ОНТ | Наадмыг зохион байгуулсан тайлан, наадамд оролцогчдын тоо | - "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг 2022 онд зохион байгуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас зохион байгуулсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох тухай цахим хуралд хамрагдлаа. Тус фестивальд оролцоход шаардагдах төсвийн төслийг боловсруулж аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүллээ.<br>Хүрсэн түвшин: Хугацаа болоогүй | 30% |
| 1.3.3.9 | Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажилд хамтран ажиллах | ОНТ | Дэмжлэг үзүүлэх | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Соёлын биет бус өвийн аймгийн бүртгэлд 583 өвлөн уламжлагч бүртгэлтэй бөгөөд тус үзлэг тооллого зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллалаа. Тооллогыг дээд шатны байгууллагаас ирэх 3-р улиралд зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.<br>Хүрсэн түвшин: Бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. | 30% |
| 1.4. | Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж стандартын шаардлагад нийцсэн соёл, урлагийн барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. | УТ, ОНТ | * | * | * | Соёлын төв, соёлын ордны орчин ба үйлчилгээний стандартын шаардлагыг хангаж ажиллах хүрээнд орон нутгийн дэмжлэгээр Замын-Үүд сумын Соёлын ордонд "Содон сод оюу" ХХК нь 1,033,7 сая төгрөгийн үнэ бүхий 87 төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Мөн Сайхандулаан сум 59,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Хатанбулаг сум 80,0 сая төгрөгийн лед дэлгэц, Өргөн сум 114,240,000 хөгжим техник хэрэгсэл, Иххэт болон Алтаншираэ сумын Соёлын төвүүд 452,000,000 төгрөгийн урсгал засвар хийлээ. Түүнчлэн Аймгийн төв номын сангийн дотор халаалт сангийн засварын ажлын тендер 2024 оны 04 сарын 26-ны өдөр зарлагдаж 2024 оны 5 сарын 06- ны өдөр тендерийг нээж 5 компани оролцсоноос "Миний Сайншанд" ХХК шалгуур үзүүлэлтийг хангаж 122,601,673 төгрөг буюу хамгийн бага үнийн саналыг ирүүлж шалгаран ажил гүйцэтгэх гэрээгээ байгуулан ажлаа эхлүүлээд байна. | 100% |
| 1.4.4 | Даланжаргалан, Хатанбулаг, Мандах сумын Соёлын төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр | ОНТ 280.0 | гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Гүйцэтгэл 30% | Даланжаргалан, Хатанбулаг сумын Соёлын төвд орон нутгийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар лед дэлгэц худалдан авахаар аймгийн ИТХ-ын 2023.12.05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолоор батлагдсан. Даланжаргалан сум тендер шалгаруулалтыг 2024.05.02-нд зарлаж 05.09-ны өдөр нээж 4 компани шалгаруулалтад оролцож материал ирүүлснээс "Сүүхүнгий" ХХК шаардлага хангаж 65,230,000 төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Хатанбулаг сум тендер шалгаруулалтыг 2024.02.06-нд зарлаж 2024.02.16-нд нээж 4 компани шалгаруулалтад оролцож материал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах | | | | | ирүүлснээс "Мандала про аудио" ХХК шаардлага хангаж 69,795,000 төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулан гэрээнд заасан хугацаанд тоног төхөөрөмжийг нийлүүлж бүрэн хүлээн авсан. Мандах сумын Соёлын төвд орон нутгийн 120,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тайзны гэрэлтүүлэг, сандал худалдан авах тендерийг 2024.01.30-ны өдөр зарлаж 2024.02.20-ны өдөр нээж 3 компани материал ирүүлснээс "Альянстрейд" ХХК шаардлага хангаж 115,379,000 төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулан гэрээнд тусгагдсан хугацаанд барааг бүрэн нийлүүлэн хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн<br>Хүрсэн түвшин: Худалдан авах тендерийг хугацаанд нь зарлан явуулж шалгаруулалтыг хийж гэрээгээ байгуулан гэрээнд заасан хугацаанд Мандах, Хатанбулаг сумын Соёлын төв тоног төхөөрөмжээ хүлээн авч үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхлэсэн. Даланжаргалан сумын Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хугацаа дуусаагүй байна.<br>Хавсралт: 13 файл | |
| 1.4.9 | Төв номын сангийн барилгын дотор халаалтын системийн засварын ажил хийх | ОНТ 142.2 | Ажлыг гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Гүйцэтгэл 100% | Аймгийн төв номын сангийн дотор халаалт сангийн засварын ажлын тендер 2024 оны 04 сарын 26-ны өдөр зарлагдаж 2024 оны 5 сарын 06- ны өдөр тендерийг нээж 5 компани оролцсоноос "Миний Сайншанд" ХХК шалгуур үзүүлэлтийг хангаж 122,601,673 төгрөг буюу хамгийн бага үнийн саналыг ирүүлж шалгаран ажил гүйцэтгэх гэрээгээ байгуулан ажлаа эхлүүлээд байна<br>Хүрсэн түвшин: 2024 оны 04 сарын 26-ны өдөр зарлагдаж 2024 оны 5 сарын 06-ны өдөр тендерийг нээж "Миний Сайншанд" ХХК шалгуур үзүүлэлтийг хангаж 122,601,673 төгрөгийн үнийн саналыг ирүүлж шалгаран, ажил гүйцэтгэх гэрээгээ байгуулан ажлаа эхлүүллээ.<br>Хавсралт: 5 файл | 70% |
| 1.4.11 | Аймгийн төв Гандантэгчинлэн хийдийн орчны тохижилтийг хийх | ОНТ 704.5 | Ажлын гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолоор орон нутгийн 600,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх төсөв батлагдсан боловч ажлын тоо хэмжээ дутуу ирээгүй учраас тендер шалгаруулалт зарлагдаагүй хүлээгдэж байна.<br>Хүрсэн түвшин: Гандандэгчилэн хийдийн гадна орчны тохижилт хийх төсөв батлагдсан боловч ажлын тоо хэмжээ гарч дуусаагүй байгаа шалтгаанаар тендер шалгаруулалт зарлагдаагүй байна. | 50% |
| 1.5. | Соёлын бүтээлч | - | - | - | - | Зууны манлай бүжиг дэглээч Төрийн соёрхолт, Ардын жүжигчин Ц.Сэвжидийн нэрэмжит Үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид дээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр | | | | | суурилж Улаанбаатар хотын мэргэжлийн бүжигчид, уран бүтээлчид нийлээд 140 шахам уран бүтээлчид хамтран бүтээсэн МУСГЗ Л.Эрдэнэбатын цомнол, УГЗ Ш.Өлзийбаярын хөгжим, бүжиг дэглээч МУСТА Х.Хашхүүгийн дэглэлт "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийн бүтээлийг эхний хагас жилд Улаанбаатар хотноо 5 удаа тоглож 4000 гаруй үзэгчдийн хүртээл болголоо.Энэхүү бүтээл нь Соёлын яамнаас зохион байгуулдаг оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчийг шалгаруулах "Мөнгөн мод" наадмын 3 номинацийн эзэн болсон амжилтыг үзүүллээ. Цагаан сарын баярыг тохиолдуулан "Ардын уламжлалт гар урлалын ай сав" цахим үзэсгэлэн зохион байгуулж 8 өвлөн уламжлагч оролцсон. Цахим үзэсгэлэнг 7662 хүн цахимаар үзэж сонирхсон. Соёлын яамнаас зохион байгуулсан “Монгол гэр” үзэсгэлэнгийн хүрээнд гэрийн тавилга, модон эдлэл, зургийн бүтээл зэрэг 3,0 сая төгрөгийн бүтээл үйлдвэрлэлийг орон нутгийн гар урчууд, бүтээлч үйлдвэрлэгчидээс худалдан авч дэмжлэг үзүүллээ. Тус үзэсгэлэнг 10,000 гаруй иргэд үзэж сонирхлоо. Үзэсгэлэнгийн хүрээнд орон нутгийн онцлог соёлыг сурталчилахад үнэтэй хувь нэмэр оруулсан МУЭ гишүүн зураач СТА Л.Халзанд СУГ-аас талархал гардуулж мөнгөн урамшуулал олголоо. Соёл урлагийн газраас санаачлан хэрэгжүүлсэн “Монгол гэр-Соёлын орон зай”-д 4 бүтээлч үйлдвэрлэгчдийг хамруулан өөрсдийн бүтээлээр үзэсгэлэн дэлгэж, олон нийтэд сурталчилан танилцууллаа. | |
| 1.5.5.1 | “Тэнгэрийн хутагт”, “Их говийн тэмээд” фестивалийг зохион байгуулах | ОНТ | арга хэмжээний тоо | - | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1 | "Их говийн тэмээ фестивалийг Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран нэгдүгээр улиралд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байсан боловч өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч онцгой байдлын горимд шилжсэнтэй холбогдуулан цуцлагдсан. Тэмээн сүргийн үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг өсгөх, тэмээчид, малчдыг туршлага солилцуулах, алдаршуулах, гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор Баянхонгор аймагт зохион байгуулагдсан ""Монголын тэмээн соёл"" улсын зөвлөгөөн, баяр наадамд Соёл урлагийн газрын Соёл гэгээрлийн мэргэжилтэн Э. Эрдэнэцэцэг, аймгийн Тэмээчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүд оролцож сайн туршлага судлалаа. Зууны манлай бүжиг дэглээч Төрийн соёрхолт, Ардын жүжигчин Ц.Сэвжидийн нэрэмжит Үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид дээр суурилж Улаанбаатар хотын мэргэжлийн бүжигчид, уран бүтээлчид нийлээд 140 шахам уран бүтээлчид хамтран бүтээсэн МУСГЗ Л.Эрдэнэбатын цомнол, УГЗ Ш.Өлзийбаярын хөгжим, бүжиг дэглээч МУСТА Х.Хашхүүгийн дэглэлт "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийн бүтээлийг эхний хагас жилд Улаанбаатар хотноо 5 удаа тоглож 4000 гаруй үзэгчдийн хүртээл болголоо.Энэхүү бүтээл нь Соёлын яамнаас зохион байгуулдаг оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчийг шалгаруулах "Мөнгөн мод" наадмын 3 номинацийн эзэн болсон амжилтыг үзүүллээ. Өөрийн орон нутагтаа 2024 оны "Тэнгэрийн хутагт"фестивалийг 3-р улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Хүрсэн түвшин: Үндэсний хэмжээнд оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг шалгаруулах "Мөнгөн мод" наадмаас 3 номинацийн эзэн шагналыг хүртсэн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амжилтыг үзүүллээ. | |
| 1.5.5.2 | Аймгийн төв, томоохон сум суурин газрыг соёлын өвөрмөц, дахин давтагдашгүй хэв шинжийг агуулсан “Бүтээлч хот” хэлбэрээр хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | ОНТ | Төлөвлөгөө батлагдсан эсэх | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Хүн амын тоо суурин соёлын өвөрмөц байдлыг илтгэх "Бүтээлч хот" төлөвлөгөөг тус аймгийн Замын-үүд, Сайншанд, Хатанбулаг сумдууд боловсруулан ажиллалаа. Аймгийн орон нутгийн төсвөөс 2 тэрбум төгрөгийг зарцуулан жуулчдыг татах, аялал жуулчлалын бүсэд аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүллээ. Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газраар аялсан гадаад дотоодын жуулчдын тоо 80719 байгаа нь 2022 онтой харьцуулахад 8.13 хувиар өслөө.Орон нутгийн төсвийн хөрөнгийн 80,0 сая төгрөгийн санхүүжилтээр 108 га талбайд “Говь парк” цэцэрлэгт хүрээлэн”-ийн зураг төсвийн ажлыг “Онч тэнхлэг” ХХК-иар гүйцэтгүүлж, 30 ААН, байгууллагын 423 ажилтан, албан хаагчдын оролцоотой 2 төрлийн 8350 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг 2 га талбайгаар нэмэгдүүлсэн. Цэцэрлэгт хүрээлэнгийн 2700 метр хашаажуулах ажлыг 95.2 сая төгрөгийн санхүүжилтээр “Ховд сафари” ХХК, “Гүний худаг гаргах, нөөцийн сав байрлуулах” ажлыг 70.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Эрхэст ундарга” ХХК-иуд гүйцэтгэсэн. Нийтийн эзэмшлийн 41 га талбайд 10 төрлийн 78330 ширхэг мод, 487 айл өрх, 92 аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн газартаа 10 төрлийн 69236 ширхэг модыг тарьснаар аймгийн хэмжээнд нийт 180104 ширхэг мод, бут сөөгийг шинээр суулгаж, 358 аж ахуй нэгж, байгууллага, 3786 иргэд оролцон ногоон байгууламжийн хэмжээг 98.2 га талбайгаар нэмэгдүүллээ.Тус аймаг ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, БНТУ, БНЭУ, АНЭУ-ын Элчин сайдын яамдууд, Оросын Шинжлэх ухаан, соёлын төв, БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий Консулын газар, "Жайка" Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, "Койка" Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг, "Near" Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын холбоо, Азийн хөгжлийн банк гэх мэт бүс нутгийн болоод олон улсын томоохон байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүллээ. Хил орчмын аялал жуулчлал, палентлоги археологийн арвин судалгааны нутаг, хадны сүг зургаараа аймагтаа тэргүүлдэг Хатанбулаг сум "Монгол улсын шилдэг сум"-аар шалгарлаа.<br>Хүрсэн түвшин: Дорноговь аймаг нь өндөр хөгжилтэй орнуудын хот, муж, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, соёл, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, техник технологи, экспорт, импортыг нэмэгдүүлэх, аймаг орон нутгаа сурталчлах, мэдээлэл солилцох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бүс нутгийн тэргүүн нарын харилцан айлчлалыг зохион байгуулах зэргээр байнгын уялдаатай ажиллалаа. Аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний байранд эрэмбэлэгдлээ. | 90% |
| 1.5.5.3 | Соёлын бүтээлч үйлдвэрлэгчди | ОНТ | Иргэн хуулийн этгээдий | - | Эхний хагас жилд: 2- | Цагаан сарын баярыг тохиолдуулан "Ардын уламжлалт гар урлалын ай сав" цахим үзэсгэлэн зохион байгуулж 8 өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулж 7662 хүн үзэж сонирхлоо. Монгол гэрийн уламжлалт урлал, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | йн үзэсгэлэн зохион байгуулах, улсын чанартай арга хэмжээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийг оролцуулах | | н тоо | | аас даашгүй иргэн хуулийн этгээдийг дэмжсэн байна Жилийн эцэст: 3-аас даашгүй иргэн хуулийн этгээдийг дэмжсэн байна | биет бус өвийн зан үйлийг сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёлын яамнаас зохион байгуулсан “Монгол гэр” үзэсгэлэнгийн хүрээнд гэрийн тавилга, модон эдлэл, зургийн бүтээл зэрэг 3,0 сая төгрөгийн бүтээл үйлдвэрлэлийг орон нутгийн гар урчууд, бүтээлч үйлдвэрлэгчидээс худалдан авч дэмжлэг үзүүлж тус үзэсгэлэнд уламжлалт гар урлалын өвлөн уламжлагч, бүтээлч үйлдвэрлэгчдийн бүтээлийг 9 хоногийн Улаанбаатар хотын төв талбайд дэлгэн 10,000 гаруй иргэд үзэж сонирхлоо. Тус үзэсгэлэнд орон нутгийн онцлыг сурталчлахад өндөр үүрэг гүйцэтгэсэн СТА зураач Л.Халзанд Соёл урлагийн газраас талархал мөнгөн урамшуулал олголоо. Соёл урлагийн газраас санаачлан хэрэгжүүлсэн “Монгол гэр-Соёлын орон зай”-д 4 бүтээлч үйлдвэрлэгчдийг хамруулан өөрсдийн бүтээлээр үзэсгэлэн дэлгэж, олон нийтэд сурталчлан танилцууллаа<br>Хүрсэн түвшин: Улсын чанартай үзэсгэлэн арга хэмжээнд орон нутгийн 10 гаруй бүтээлч үйлдвэрлэгчдийн бүтээлийг 10,000 гаруй иргэн олон нийтэд сурталчлан, аймгийн хэмжээний бүтээлч үйлдвэрлэгчдийн 2 үзэсгэлэн арга хэмжээг зохион байгууллаа.<br><br>Хавсралт: 10 файл | |
| 1.5.5.4 | Соёл урлагийн мэргэжлийн холбоодыг чадавхжуулах, хамтран ажиллах | ОНТ | Байгууллагын тоо | 3 | Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 2 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт хамаарах "Баялаг бүтээгчдийн холбоо", Монголын зохиолчдын "Хурмаст тэнгэр" төв, зураач урчуудын "Их дөмөн" холбоо, ЕБС-насны болон насанд хүрэгчдийн хувийн бүжгийн клубууд, студи интертаймент уран бүтээлчид,чөлөөт уран бүтээлчдийн "Үлэмжийн чанар" нэгдэл, оюуны спортын чиглэлийн клуб дугуйлан, орон нутгийн "Ялалт", "Өнөөгийн Дорноговь" сонины газрууд, "DSB", "DTV" телевизүүд, мэргэжлийн гэрэл зургийн холбоо зэрэг 20 гаруй мэргэжлийн эвлэл холбоодын удирдлага, гишүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлсээр ирлээ. "Соёл урлагийн ажилтны зөвлөгөөн","Спортын бага наадам", "Соёлын сэргэлт-2023, 2024" аян, тэмдэглэлт ой, төвлөрсөн арга хэмжээнүүд, нутгийн уран бүтээлчдийг алдаршуулах тоглолтууд зэрэг 8 үйл ажиллагаанд хамтран ажилласнаас гадна сумдын Соёлын төвүүд хамтын ажиллагаагаа тэлсээр байна.2024 онд "Дорноговьд үйлдвэрлэв" төвийг ашиглалтад оруулж байгаатай холбогдуулан гар урлалын төрлийн өрхийн үйлдвэрлэгчид зохион байгуулалтад орж бие даасан холбоо шинээр байгууллаа. Ахмадын "Маанийн холбоо" нэгдсэн зохион байгуулалтад орж дүрмээ батлан тамга тэмдэгтэй болоход арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллалаа. Морин хуур, уртын дуу, хөгжмийн чиглэлийн дугуйлангуудын ажиллах нөхцлийг ханган "Саран Хөхөө" театрын хуучин барилгыг Сайншанд сумын соёлын ордон болгох бодлого барин төсвийн төсөөлөл, бүтэц, орон тооны тооцоо судалгааг гарган ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байсан мэргэжлийн эвлэл холбоотой хамтран ажилласнаар хууль эрх зүйн чадамжтай, өөрсдийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүрэм, тамга тэмдэгтэй болж нэгдсэн зохион байгууллалтад орж эхэллээ. Соёлын яамны бодлогын зорилтуудаар хамтран ажиллах чиглэлийг Соёл, урлагийн газраас арга зүй, мэргэжлийн дэмжлэг авдаг боллоо. | |
| 1.6. | Гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх | ОНТ | - | - | - | Монголд зочлох жилийн хүрээнд сүүлийн 3 жил дараалан зохион байгуулагдаж байгаа "Нүүдэлчин" фестивалын бэлтгэлийг хангаан Соёлын яамны дэмжлэг 30.0 сая, орон нутгийн дэмжлэг 10.0 сая нийт 40.0 сая төгрөгөөр өөрийн онцлог бүхий сийлбэртэй 8 ханатай гэрийг ширээ, сандлын хамт гэрийн мод урлаачдаар бүтээлгэлээ. Соёлын сэргэлт 2024 аяны хүрээнд зохион байгуулсан монгол гэрийг хүүхэд залуust болон гадаад дотоодын жуулчдад “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг суртачлан таниулах зорилгоор Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас санаачлан зохион байгуулсан “Гэр” үзэсгэлэнд “Ноён хутагтын өргөө” халх угсаатны 8 ханатай гэрийг бүтээн Улаанбаатар хотноо 9 хоног сурталчлан таниулж 11700 гаруй иргэнд сурталчилж ажиллалаа. Монгол ахуй, өв соёлоо сурталчилж хүүхэд багачууд иргэд олон нийтэд соёлын үйлчилгээг хүргэх зорилгоор Монгол гэр-Соёлын орон зай эвент арга хэмжээг санаачлан тусгай хөтөлбөрийн дагуу орон нутагтаа анх удаагаа зохион байгууллаа. Хүүхэд хөгжлийн дугуйлангуудын үзүүлэх тоглолт, үндэсний бичгийн үзэсгэлэн, гар урлал, бүтээлч үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн, яруу найргийн уншлага, уншигч зохиолчдын уулзалт, угийн бичгийн сургалт, музейн боловсролын хөтөлбөрүүдийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хэрэгжүүлэн 9 хоногийн хугацаанд 950 гаруй хүний хүртээл болголоо.Мөн аймгийн орон нутгийн онцлог, ноён хутагт, Ханбаянзүрх хайрхны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж жуулчдыг татах арга хэмжээг зохион байгууллаа. Орон нутагт ирэх гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор гуравдугаар улиралд орон нутгийн онцлог шингэсэн "Тэнгэрийн хутагт" фестивалийг зохион байгуулахаар төлөвлөсөн. | 100% |
| 1.6.1 | Орон нутагт ирэх гадаад, дотоодын жуулчдыг нэмэгдүүлэх чиглэлээр багц арга хэмжээ зохион байгуулах | ОНТ | Хийгдсэн ажил | 2 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 | Тус аймаг нь Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн, Баянбулаг Ханги -Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болж хөгжих ирээдүйтэй.Улсын төсвийн 16705.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 700 хүний суудалтай Саран Хөхөө театр, Замын-Үүд суманд 500 хүний суудалтай Соёл, урлагийн ордны барилгын ажлыг эхлүүлэн барилгын явц 90 хувьтай явагдаж байна. Төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний дагуу Дэлгэрэх, Эрдэнэ суманд шинээр Соёлын төвийн барилга барих ажлыг эхлүүлсэн. Эхний хагас жилд орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн 10 гаруй уран бүтээл, арга хэмжээг шинээр зохион байгуулан зарим арга хэмжээг брэнд болгон хөгжүүлж орон нутгаа сурталчилан ажиллалаа.Соёлын сэргэлт 2024 аяны хүрээнд зохион байгуулсан монгол гэрийг хүүхэд залуust болон гадаад дотоодын жуулчдад | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг суртачлан таниулах зорилгоор Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас санаачлан зохион байгуулсан “Гэр” үзэсгэлэнд “Ноён хутагтын өргөө” халх угсаатны 8 ханатай гэрийг бүтээн Улаанбаатар хотноо 9 хоног сурталчлан таниулж 11700 гаруй иргэнд сурталчилж ажиллалаа. Мөн аймгийн орон нутгийн онцлог, ноён хутагт, Ханбаянзүрх хайрхны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж жуулчдыг татах арга хэмжээг зохион байгууллаа. Орон нутагт ирэх гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор гуравдугаар улиралд орон нутгийн онцлог шингэсэн "Тэнгэрийн хутагт" фестивалийг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br><br>Хүрсэн түвшин: “Тэнгэрийн хутагт” бүжгэн жүжиг, “Гэтэлгэх мөр” туульсийн хөгжимт жүжиг, “Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүд, “Их говийн тэмээ” өв соёлын фестиваль, ерөөлч, магтаалчдын наадам зэрэг соёлын биет болон биет бус оюуны үнэт өв, бүтээлийг олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүллээ.<br><br>Хавсралт: 6 файл | |
| 1.6.2 | Орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн орон нутгийн бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх | ОНТ | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн | 2 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 | Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнд Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейтэй хамтран 3 боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж 1700 гаруй иргэнийг хамруулж 9 хоногийн турш тус үзэсгэлэнг 10,000 гаруй иргэд үзэж сонирхлоо. Аймгийн музей, сургалт судалгааны төвөөс "Музейтэй Дорноговь" сарын аяныг өрнүүлж "Өвлөн уламжлагчдын тоглолт", Шог зураач Р.Гал-Одын шог зургийн үзэсгэлэн, "Мөнгөн тэмдэгт зоосон мөнгө", "Metal art" зэрэг 8 үзэсгэлэнг зохион байгуулж 3200 гаруй иргэн үзэж сонирхлоо. Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачуудад сурталчлан мэдлэг олгох зорилгоор Соёл урлагийн газраас төрийн болон хувийн хэвшлийн байгууллага клубуудтэй хамтран "Монгол гэр-Соёлын орон зай" соёлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж 9 хоногийн турш өдөр бүр өөр өөрийн онцлог бүхий өв соёлоо сурталчилж 950 гаруй иргэдэд хүргэлээ. Сайншандын 10-р цэцэрлэгтэй хамтран "Монгол бахархлын өдөр" арга хэмжээг Монгол гэрт хийж СӨБ-ийн 115 хүүхэд хамрагдлаа. Зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит Үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид дээр суурилж нийт 140 гаруй уран бүтээлчид хамтран бүтээсэн МУСГЗ Л.Эрдэнэбатын цомнол, УГЗ Ш.Өлзийбаярын хөгжим, бүжиг дэглээч МУСТА Х.Хашхүүгийн дэглэлт "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийн бүтээлийг эхний хагас жилд Улаанбаатар хотноо 5 удаа тоглож 4000 гаруй үзэгчдийн хүртээл болгосон бөгөөд энэхүү бүтээл нь орон нутгийн онцлог өнгө төрхийг шингээж жуулчдыг татах зорилготой юм. Хүүхэд багачуудад орон нутгийн соёлын дурсгалт газруудыг танилцуулах зорилгоор “Сити тур”аялалыг ЕБ-ын 5 сургуулийн 81 сурагчдыг хамруулан Хамарын хийд, Хан баянзүрх хайрхан орчмын аялалыг зохион байгуулсан. Монгол , БНХАУ- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын хамтарсан "Талын түнш" хээрийн сургуулилтын арга хэмжээнд "Гэр" үзэсгэлэн дэлгэн үзүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Арга хэмжээний тоо-13 Үйлчилгээ авсан иргэдийн тоо 15400 | |
| 1.6.3 | Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан эвент арга хэмжээ | 1 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2 | Монгол ахуй, өв соёлоо сурталчилж хүүхэд багачууд иргэд олон нийтэд соёлын үйлчилгээг хүргэх зорилгоор Монгол гэр-Соёлын орон зай эвент арга хэмжээг санаачлан тусгай хөтөлбөрийн дагуу анх удаагаа зохион байгууллаа. Хүүхэд хөгжлийн дугуйлангуудын үзүүлэх тоглолт, үндэсний бичгийн үзэсгэлэн, гар урлал, бүтээлч үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн, яруу найргийн уншлага, уншигч зохиолчдын уулзалт, угийн бичгийн сургалт, музейн боловсролын хөтөлбөрүүдийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хэрэгжүүлэн 9 хоногийн хугацаанд 950 гаруй хүний хүртээл болголоо.Монголд зочлох жилийн хүрээнд сүүлийн 3 жил дараалан зохион байгуулагдаж байгаа "Нүүдэлчин" фестивалын бэлтгэлийг ханган Соёлын яамны дэмжлэг 30.0 сая, орон нутгийн дэмжлэг 10.0 сая нийт 40.0 сая төгрөгөөр өөрийн онцлог бүхий сийлбэртэй 8 ханатай гэрийг ширээ, сандлын хамт гэрийн мод урлаачдаар бүтээлгэлээ.<br>Хүрсэн түвшин: Зохион байгуулсан эвент арга хэмжээ 1<br>Хавсралт: 3 файл | 100% |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 3.1. | Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх | ОНТ, УАЗ | - | - | - | Соёлын яам байгуулагдсанаар 21 аймагт Соёл, урлагийн газруудыг 2022 онд байгуулсан. Байгуулагдсан цагаас эхлэн аймгийн соёлын салбарын харьяа төрийн өмчит 17 байгууллага, хувийн 2 хэвшилд зөвлөн туслах чиг үүргээр ажилласан. Тайлант оны эхний хагас жилд аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр, Өргөн сумын Соёл спортын төв болон Замын-Үүд сумын Соёл, спортын ордонд зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, дотоод үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, цаашид ажил сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг авч ажилласан. Мөн өдөр тутмын үйл ажиллагаанд харьяа байгууллагадад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн түүнчлэн Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу жил бүрийн 01 сарын 20-ны дотор харьяа анхан шатны байгууллагуудаас жилийн эцсийн статистик мэдээг хүлээн авч хэвшсэн боловч харьяа байгууллагуудад хүний нөөцийн хомсдол болон тогтвор суурьшилтай ажилладаггүйгээс шалтгаалан статистик мэдээний арга зүйн зөвлөлөөг үргэлж өгөх шаардлага үүсдэг. Тиймээс жилийн эцсийн статистик мэдээ хэрхэн гаргах тухай арга зүйн цахим сургалтыг 2024 оны 01 сарын 15-ны өдөр зохион байгуулж 22 ажилтан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан. Сургалтаар авсан мэдлэг, мэдээлэлд үндэслэн статистик мэдээгээ гаргаж сурсан. Мөн Соёлын яамнаас статистикийн системийг хэрэглээнд нэвтрүүлж байгаа бөгөөд системийг танилцуулах 3 хоногийн цахим сургалтад 19 албан хаагч, 2021-2023 оны мэдээг системд оруулах дадлага ажил сургалтад 14 албан хаагч хамрагдсан Соёлын яамнаас цахим шилжилтийн хүрээнд салбарын статистикийн системийн хөгжүүлэлтийг дуусган хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын статистик мэдээ хариуцсан бүртгэлийн ажилтнуудад системийн сан бүрдүүлэх чиглэлээр дадлага ажил сургалтыг танхимаар зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулллаа. | |
| 3.1.1 | Соёлын салбарын байгууллагууда д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | ҮАЗ | Зөвлөн тусласан тоо | 7 | Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 8 | Соёлын яам байгуулагдсанаар 21 аймагт Соёл, урлагийн газруудыг 2022 онд байгуулсан. Байгуулагдсан цагаас эхлэн аймгийн соёлын салбарын харьяа төрийн өмчит 17 байгууллага, хувийн 2 хэвшилд зөвлөн туслах чиг үүргээр ажилласан. Тайлант оны эхний хагас жилд аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр, Өргөн сумын Соёл спортын төв болон Замын-Үүд сумын Соёл, спортын ордонд зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, дотоод үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, цаашид ажил сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг авч ажилласан. Мөн өдөр тутмын үйл ажиллагаанд харьяа байгууллагадад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн түүнчлэн Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу жил бүрийн 01 сарын 20-ны дотор харьяа анхан шатны байгууллагуудаас жилийн эцсийн статистик мэдээг хүлээн авч хэвшсэн бөгөөд статистик мэдээ хэрхэн гаргах тухай арга зүйн цахим сургалтыг 2024 оны 01 сарын 15-ны өдөр зохион байгуулж 22 ажилтан хамрагдсан. Сургалтаар авсан мэдлэг, мэдээлэлд үндэслэн статистик мэдээгээ гаргаж сурсан. Соёлын яамнаас цахим шилжилтийн хүрээнд салбарын статистикийн системийн хөгжүүлэлтийг дуусган хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын статистик мэдээ хариуцсан бүртгэлийн ажилтнуудад системийн сан бүрдүүлэх чиглэлээр дадлага ажил сургалтыг танхимаар зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулллаа.<br>Хүрсэн түвшин: Зөвлөн тусласан байгууллагын тоо 17 /давхарсан тоогоор 32/<br>Хавсралт: 6 файл | 100% |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 4.1. | Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг | УТ , ОНТ | - | - | - | Соёл урлагийн газар нь байгуулагдсан цагаас эхлэн Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. Энэ хүрээнд тайлант оны эхний хагас жилд: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх | | | | | хэрэгжилтийн хүрээнд салбарын ёс зүйн зөвлөлийг "Салбарын ёс зүйн дэд хороо" болгон өөрчилж Соёл урлагийн газрын даргын 2024.01.19-ний өдрийн А/02 тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. Авлигын эсрэг хууль болон холбогдох хууль эрх зүйн хүрээнд 6 албан хаагч хуулийн хугацаанд 2023 оны ХАСХОМ мэдүүлгээ гаргасан. Соёл урлагийн газраас төр, хувийн хэвшлийн соёлын салбарын байгууллагуудад цаг үеийн чанартай мэдээлэл өгөх, шинэ гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулах, төлөвлөгөө тайлан бичих, статистик мэдээ гаргах арга зүй зэрэг 6 цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 157 хүн хамрагдсан. Аймгийн соёлын салбарын 18 байгууллагаас батлагдсан маягтын дагуу жилийн эцсийн СУ мэдээ, СУХС мэдээ, 1,2-р улирлын статистик мэдээг авч хянан нэгтгэж дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Түүнчлэн холбогдох хууль эрх зүйн хүрээнд архив албан хэрэг хөтлөлт, төсөв санхүүгийн тайлан, бүх нийтийн соёлын боловсрол, хүүхэд хамгааллын албан даалгавар болон улс болон орон нутгийн шинжтэй бүхий л үйл ажиллагааг албан ажилдаа хэрэгжүүлж ажиллалаа. | |
| 4.1.1 | Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар дэмжлэг үзүүлэх | Улсын болон Орон нутгийн төсөв | Хөнгөлттэй нөхцлөөр сургах Ажилтны нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн байна | 2023 онд цахим болон танхимаар зохион байгуулсан нийт 5 сургалтад давхардсан тоогоор 216 соёлын ажилтныг хамруулсан | Эхний хагас жилд: Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр өмнөх оны хүрсэн түвшингээс буураагүй байх Жилийн эцэст: Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр өмнөх оны хүрсэн түвшингэ | Эхний хагас жилээр танхимын сургалтаар СУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран соёлын төвийн дуу хөгжмийн багш нарыг чадавхжуулах, Америкийн Элчин Сайдын яамнаас зохион байгуулсан “Америкийн соёл мэдээллийн төвийн албан хаагчдыг чадавхжуулах, ХНУША-н “Хүний нөөцийн менежмент”-ээр чадавхжуулах сургалтуудад 12 албан хаагчдыг хамруулан байгууллагаас сургалтын төлбөрт 2,642,500 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Мөн цахимаар “Музейн нийгэм соёлын үйл ажиллагаа”, Монголын Үндэсний Музейгээс “Музейн ажилтнуудын ур чадварыг сайжруулах”, “Номын сангийн үндэс”, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Байгууллагын архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт боловсруулах арга зүй”, “Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сэдэвт 2 удаагийн мэргэшүүлэх, Орон нутаг судлах танхимын ажилтан, Музей сургалт, судалгааны төвөөс зохион байгуулагдсан “Соёлын биет бус өвлөн уламжлагчдын судалгааг гаргах, зөвлөн туслах” сургалтуудад 37 албан хаагч хамрагдаж байгууллагаас сургалтын төлбөрт 241,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Музей сургалт, судалгааны төвийн захирал СУИС-д Соёл судлалын докторантад, эрдэм шинжилгээний ажилтан МУИС-д археологийн чиглэлээр магистрт, Саран хөхөө театрын гоцлол хөгжимчин А.Энхнаран СУИС-ийн хөгжмийн зохиолчийн ангид АЗД-н дэмжлэгтэйгээр суралцаж байна. Монгол улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Соёлын яамнаас музейн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Хонгконгт болсон “MUSEUM SUMMIT-2024” арга хэмжээнд Музейн захирал хамрагдсан. Саран хөхөө театр нь тогтвор суурьшилтай ажилласан 1 албан хаагчид 8,424,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон. Шилжин суурьшиж ажиллаж байгаа мэргэжлийн албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эс бууруулаагүй байх. Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | хаагчдын нийгмийн баталгааг хангаж сумдын төрийн албан хаагчын байранд 5 албан хаагчыг хөнгөлөлттэй нөхцлөөр амьдрах орчинг шийдэж өгсөн. Төрийн захиргаанд тогтвор суурьшилтай ажилласан 2 албан хаагчид 19,016,200 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Эхний хагас жилийн байдлаар соёлын салбарын албан хаагчдыг мэргэшлүүлэх, хөгжүүлэх сургалтад давхардсан тоогоор 228 албан хаагч хамрагдаж 5 албан хаагчыг хөнгөлөлттэй нөхцөлөөр төрийн албан хаагчын байраар хангаж, 3 албан хаагчид 27,440,200 төгрөгний мөнгөн тэтгэмж олгож нийгмийн баталгааг хангаж ажиллалаа.<br>Хавсралт: 3 файл | |
| 4.1.2 | Соёлын салбарын статистикийн мэдээ, тайланг хугацаанд нь үнэн, бодитой гаргаж ирүүлэх, тайланд өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулах | - | Статистикийн 12 маягтаар бүрэн хугацаандаа ирүүлсэн мэдээ, тайлангийн тоо, хувь Улирал тутмын судалгааны үзүүлэлтийг нэгтгэж ирүүлсэн мэдээ, хувь | 2023 оны үйл ажиллагааны тайлан, ажиллагчдын статистик мэдээг 11 маягтаар, хөрөнгө, санхүүгийн мэдээг 1 маягтаар ирүүлсэн. | Эхний хагас жилд: Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны болон ажиллагчдын статистик мэдээг 11 маягтаар бүрэн гаргаж нэгтгэн цагалбарт хугацаанд багтаан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газарт | Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу жил бүрийн 01 сарын 20-ны дотор харьяа анхан шатны байгууллагуудаас жилийн эцсийн статистик мэдээг хүлээн авч хэвшсэн. Дээрх батлагдсан анхан шатны 8 маягтын дагуу төрийн өмчийн-17, хувийн хэвшлийн-1, нийт 18 байгууллагаас 2023 оны соёл, урлагийн салбарын статистик мэдээг хуулийн хугацаанд авч, хянаж ажиллалаа. Анхан шатны 18 нэгжээс ирүүлсэн мэдээг хянан захиргааны маягтын /3-СУ, 3-СТ, 3-НС, 3-М, 3-УБ 3-К /дагуу нэгтгэж, илтгэх хуудасны хамт цагалбарт хугацаанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн. Статистик мэдээ хэрхэн гаргах тухай арга зүйн цахим сургалтыг 2024 оны 01 сарын 15-ны өдөр зохион байгуулж 22 ажилтныг хамрууллаа. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайдын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн А/300 дугаар тушаалаар баталсан улирлын мэдээний маягтын дагуу Дорноговь аймгийн Соёл, урлагийн салбарын 18 байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээг авч, нэгтгэлийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт цаглабар хугацаанд багтаан хүргүүллээ.<br>Хүрсэн түвшин: Аймгийн соёлын салбарын 18 байгууллагаас батлагдсан маягтын дагуу жилийн эцсийн СУ мэдээ, СУХС мэдээ, 1,2-р улирлын статистик мэдээг авч хянан нэгтгэж дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ирүүлсэн байна Жилийн эцэст: Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны болон ажиллагчдын статистик мэдээг 11 маягтаар бүрэн гаргаж нэгтгэн цагалбарт хугацаанд багтаан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Соёл, урлагийн газарт ирүүлсэн байна | | |
| 4.1.3 | Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдлын үнэлгээг 20 хувиар нэмэгдүүлнэ. | ОНТ | Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдлын үнэлгээг нэмэгдүүлэх | - | Эхний хагас жилд: Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдлын үнэлгээ | СУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран соёлын төвийн дуу хөгжмийн багш нарыг чадавхжуулах, Америкийн Элчин Сайдын яамнаас зохион байгуулсан “Америкийн соёл мэдээллийн төвийн албан хаагчлыг чадавхжуулах, ХНУША-н “Хүний нөөцийн менежмент”-ээр, СУИС-аас зохион байгуулсан Бүжиг заах арга зүй 2,5 кредитын 90 цагийн сургалтуудад 12 албан хаагчийг хамруулан байгууллагаас сургалтын төлбөрт 2,642,500 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Мөн цахимаар “Музейн нийгэм соёлын үйл ажиллагаа”, Монголын Үндэсний Музейгээс “Музейн ажилтнуудын ур чадварыг сайжруулах”, “Номын сангийн үндэс”, “Байгууллагын архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Жилийн эцэст: Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдлын үнэлгээ | жагсаалт боловсруулах арга зүй", "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сэдэвт 2 удаагийн мэргэшүүлэх, Орон нутаг судлах танхимийн ажилтан, Музей сургалт, судалгааны төвөөс зохион байгуулагдсан "Соёлын биет бус өвлөн уламжлагчдын судалгааг гаргах, зөвлөн туслах" сургалтуудад 37 албан хаагч хамрагдаж байгууллагаас сургалтын төлбөрт 241,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Соёл урлагийн газраас аймгийн соёлын салбарын байгууллагуудад цаг үеийн чанартай мэдээлэл өгөх, шинэ гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулах, төлөвлөгөө тайлан бичих, статистик мэдээ гаргах арга зүй зэрэг 6 цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 157 хүн хамрагдсан. МССТ-ийн захирал СУИС-д Соёл судлалын докторантад, эрдэм шинжилгээний ажилтан МУИС-д археологийн чиглэлээр магистрт суралцаж байгаа бөгөөд музейн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Хонгконгт болсон "MUSEUM SUMMIT-2024" арга хэмжээнд музейн захирал хамрагдаж туршлага судлаж оролцосн. Саран хөхөө театрын гоцлол хөгжимчин СУИС-ийн хөгжмийн зохиолчийн ангид аймгийн Засаг Даргын дэмжлэгтэйгээр суралцаж байна. Мөн Соёлын яамнаас соёлын салбарын удирдах ажилтан, санхүү бүртгэлийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж 22 хүнийг хамруулсан.<br>Хүрсэн түвшин: Эхний хагас жилийн байдлаар давтагдсан тоогоор 228-н соёлын салбарын албан хаагч мэргэжлийн мэргэшүүлэх сургалтуудад хамрагдсан. Сургалтад хамрагдсан албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн сайжирч байна.<br>Хавсралт: 6 файл | |
| 4.1.4 | Соёлын салбарын байгууллагуудын 2025 оны төсвийн төсөөллийг нэгтгэж дээд шатны байгууллагад хүргүүлэх хуваарилах хэрэгжилтийн зохицуулах. | - | гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд: Хэрэгжилтийг хангаж ажиллах Жилийн эцэст: Дээд шатны байгууллагад хүргүүлсэн байх. | Төслийн төсөөлөл гаргаж өгөх хуулийн хугацаа болоогүй. Соёлын салбарын 17 байгууллагад 2025 оны төсвийн төсөөллийг хэрхэн хийх Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 211 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан эдийн засгийн ангилалаар гаргаж иргүүлэх чиглэлийг өгч төсвийн төслөө гаргаж эхлээд байна<br>Хүрсэн түвшин: Соёлын салбарын 17 байгууллага 2025 оны төсвийн төсөлөө хэрхэн хийх чиглэлийг авч төсвийн төсөлөө гаргаж эхлээд байна | 70% |
| 4.1.5 | Салбарын | - | гүйцэтгэл | - | Эхний | Соёлын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 3/15 тоот албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагууд ын санхүүгийн тайланг нэгтгэх | | ээр | | хагас жилд: тайланг нэгтгэсэн байх Жилийн эцэст: тайланг нэгтгэсэн байх | бичгээр аймгийн соёлын салбарын 18 байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хүргүүлэх хуваарийн дагуу санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хийж хуулийн хугацаанд нь тайлангаа хүргүүлэн санхүүгийн тайлангийн зөрчилгүй гэж үнэлэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж харьяа төрийн өмчийн 17 байгууллагын санхүүгийн зарцуулалтын сарын мэдээг журамд нийцүүлэн сар болгон https://medee4.dynamic.mn/ цахим сайтаар хүлээн авч, хянаж зөрчил дутагдлыг арилгуулан баталгаажуулалтыг хийн ажиллаж байна. Тайлант оны эхний хагас жилийн тайланг журмын дагуу цаасаар болон e-report.mof.gov.mn цахим сангаар хүлээн авч нэгтгэлийг хийж ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, сарын мэдээг харьяа 17 байгууллагаас хуулийн хугацаанд нь хүлээн авч хянаж зөрчил дутагдалыг тухай бүрд нь арилгуулж баталгаажуулан холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа<br>Хавсралт: 3 файл | |
| 4.1.6 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг албан хаагчдад сурталчлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Сургалтын тоо | 7 | Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 8 | Соёл, урлагийн газар байгуулагдсан цагаас эхлэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл”, Аймгийн Засаг даргын 2021 оны “Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 дугаарын албан даалгаврыг салбарын ажилтан албан хаагчдад сурталчлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа. Энэ хүрээнд 2022 оны 07 дугаар сард салбарын ёс зүйн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байгаад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" батлагдсан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд салбарын ёс зүйн зөвлөлийг "Салбарын ёс зүйн дэд хороо" болгон өөрчилж Соёл урлагийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/02 тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар салбарын албан хаагчтай холбоотой 1 өргөдөл гомдол ирсэн ба Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн тогтоолоор байгуулсан ажлын хэсэгтэй хамтран салбарын ёс зүйн дэд хорооны 2 албан хаагч өргөдөл гомдолд холбогдсон албан хаагчдын ажлын байран дээр очиж ажилласан. Албан хаагчдын бичиг баримт, албан хэрэг хөтлөлттэй танилцах, ярилцлагын аргаар тайлбар мэдээлэл авах зэрэг аргуудыг ашиглаж ажилласан ба санал дүгнэлтийг ажлын 2 хоногт багтаан тухайн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ч.Нандин-Эрдэнэ /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/-д цаасаар болон файлаар өгч хамтран ажиллалаа. Төрийн албаны зөвлөлөөс Дорноговь аймагт ажиллах үедээ зохион байгуулсан Ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад салбарын ёс зүйн дэд хороо болон салбарын албан хаагчдыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруууллаа. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 02/751 дугаар албан бичгийн дагуу харьяа байгууллагуудад чиглэл хүргүүлэн байгууллага тус бүр ёс зүйн сургалтыг 155 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" батлагдсан гарсантай холбогдуулан салбарын ёс зүйн зөвлөлийг "Ёс зүйн дэд хороо" болгон Соёл урлагийн газар, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Номын сангаас төлөөлөл оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Мэдээллийн самбарт ёс зүйн дэд хорооны мэдээллийг нийтэд ил тод байршуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт давхардсан тоогоор 200 гаруй алба хаагчдыг сургалтад хамруулан ажиллалаа.<br>Хавсралт: 5 файл | |
| 4.1.7 | Төр салбар аймаг орон нутгийн шагнал урамшуулалд тодорхойлох уламжлах | - | Шагналын тоо | 30 | Эхний хагас жилд: 32 Жилийн эцэст: 40 | Соёл урлагийн салбарт үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах дэмжих зорилгоор Салбарын нэгж байгууллагуудаас ирүүлсэн 33 хүний шагналын материалыг хүлээн авч Соёлын яамны Төрийн захиргаа удирдлагын газарт албан бичгээр материалыг хүргүүлэн "Соёлын сэргэлт-2024" удирдах ажилтаны зөвлөгөөний үеэр Засгийн газрын шагнал Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр Замын-Үүд сумын Соёл, спортын ордоны дарга Э.Саранцэцэг, Сайхандулаан сумын Соёлын төвийн дарга М.Тогтохбаяр, Соёлын яамны "Жуух бичиг"-ээр Соёл урлагийн газрын дарга У.Ганбаатар нарын шагналыг гардуулан өгсөн. "Алтан гадас" одонд тодорхойлсон Зүүнбаян тосгоны Соёлын төвийн номын санч Ж.Баяраагийн материалыг дэмжин уламжиллаа. Мөн аймгийн Засаг даргын өргөмжлөлөөр шагнуулахаар 14 хүний материалыг албан бичгээр хүргүүлж шагналыг албан хаагчдад гардуулан өгсөн.<br>Хүрсэн түвшин: Салбартаа үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах дэмжих зорилгоор Салбарын шагналаар -6, Хөдөлмөрийн хүндэт медаль шагналаар-2, "Алтан гадас" одонгоор-1, Аймгийн Засаг даргын шагналаар -14, СУГ-ын даргын шагналаар-10 нийт 33 хүнийг шагналд тодорхойлж эхний хагас жилийн байдлаар 27 хүний шагналыг гардуулж өгсөн.<br>Хавсралт: 4 файл | 90% |
| 4.1.8 | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг хууль журмын дагуу хөтлөх | - | Баримт бичгийн эргэлтийн хэмжээ | 17300 | Эхний хагас жилд: 7000 Жилийн эцэст: | Соёлын салбарын 17 нэгж байгууллага нь Засгийн газрын 2022 оны 360 дугаар тогтоолоор батлагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, заавар, журмын хүрээнд өдөр тутмын албан хэрэг хөтлөлтийг хийж ажиллаж байна. Мөн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан мөрдлөг болгон ажиллалаа. Улсын Архивын Ерөнхий газраас зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 17000 | байгуулсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүйн" сургалтад Соёл урлагийн газар, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Номын сангийн бичиг хэргийн ажилтнууд хамрагдсан. Нэгж байгууллагууд архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг аймгийн Архивын газраар баталгаажуулан архивын нэгж үүсгэн өмнөх оны баримтуудыг архивласан. Мөн Засгийн газрын 2022 он 212 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон “албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг баримтлан албан бичгүүдээ цахим гарын үсгээр баталгаажуулж илгээж эхэлсэн. ERP буюу цахим системийг нэгж байгууллагууд бүгд ашиглаж албан бичгийг цахимаар явуулж хэвшээд байна. Нэгж байгууллагуудад өдөр тутамдаа архив албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөн явуулах мэргэжил арга зүйн зөвлөгөөг өдөр тутамдаа өгч ажиллаж байна. Тоон гарын үсгийг 2 байгууллага албан хэрэгцээнд бүрэн ашиглаж хэвшээд байгаа бөгөөд бусад нэгж байгууллагад тоон гарын үсгийг ашиглах чиглэлийг өгч ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүйн" сургалтад хамрагдсанаар албан хэрэг хөтлөлтийн стандарын дагуу зөв хөтлөн явуулж мөн нэгж байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг хүргэн ажиллаж байна. Соёлын салбарын байгууллагууд бүгд ERP цахим системийг ашигласнаар албан бичгийг хурдан шуурхай хүргэж цаасан хэрэглээг багасгаж төсвийн хэмнэлтийг хийж ажиллаж байна.<br>Хавсралт: 3 файл | |
| 4.1.1.10 | Соёлын төв, Соёлын ордны орчин үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх | ҮАЗ | тайлангийн тоо | Тайлангийн тоо | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Соёлын төв, соёлын ордны орчин ба үйлчилгээний стандартын шаардлагыг хангаж ажиллах хүрээнд орон нутгийн дэмжлэгээр Замын-Үүд сумын Соёлын ордонд "Содон сод оюу" ХХК нь 1,033,7 сая төгрөгийн үнэ бүхий 87 төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Мөн Сайхандулаан сум 59,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 220,0 сая төгрөгний их засвар, Хатанбулаг, Даланжаргалан сумдуудад 80,0 сая төгрөгийн лед дэлгэц, Мандах сум 120,0 сая төгрөгний тоног төхөөрөмж, тавилга, Өргөн сум 114,240,000 хөгжим техник хэрэгсэл, Иххэт болон Алтанширээ сумын Соёлын төвүүд 452,000,000 төгрөгийн урсгал засвар хийлээ. Түүнчлэн Аймгийн төв номын сангийн дотор халаалт сангийн засварын ажлын тендер 2024 оны 04 сарын 26-ны өдөр зарлагдаж 2024 оны 5 сарын 06- ны өдөр тендерийг нээж 5 компани оролцсоноос "Миний Сайншанд" ХХК шалгуур үзүүлэлтийг хангаж 122,601,673 төгрөг буюу хамгийн бага үнийн саналыг ирүүлж шалгаран ажил гүйцэтгэх гэрээгээ байгуулан ажлаа эхлүүлээд байна. Соёл урлагийн байгууллагуудын орчин ба үйлчилгээний стандартын судалгааг гаргаж Соёлын яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 2024 оны хагас жилийн байдлаар 7 сумын соёлын төв, аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төв номын сангийн орчин үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br><br>Хавсралт: 11 файл | |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 85,1% | | | | | | | |

*ТАЙЛАН ХЯНАСАН:*

*СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА* *У.ГАНБААТАР*

*ТАЙЛАН НЭГТГЭСЭН:*

*ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ*

*ЦАХИМЖИЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН* *А.НАРАНЖАРГАЛ*

2024.06.12